

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-33

<i>1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	4-22
<i>2.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	22-33

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
05 дугаар сарын 03-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ж.Батсуурь, С.Бямбацогт, Ц.Мөнх-Оргил;
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Сүхбаатар, Ж.Эрдэнэбат.

Нэг.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Ариунням, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Өрийн удирдлагын тасгийн дарга Л.Эрдэнэбадрах, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын дарга Г.Батзориг, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Г.Мөнхбаатар, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах хорооны Ажлын албаны дарга Д.Баярдорж, Нийслэлийн захирагчийн Ажлын албаны төлөвлөлт хариуцсан шинжээч Ц.Батгэрэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Энхжаргал, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн гэрээ, эрх зүйн мэргэжилтэн М.Уранбилэг, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр, мөн захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Ц.Баянмөнх, Б.Баярмаа, П.Хулан, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, М.Оюунчимэг, Т.Доржханд, Г.Ганболд нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд

С.Амарсайхан, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн 9 цаг 43 минутаас 10 цаг 27 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Н.Энхболд: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Ариунням, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Өрийн удирдлагын тасгийн дарга Л.Эрдэнэбадрах, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын дарга Г.Батзориг, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Г.Мөнхбаатар, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах хорооны Ажлын албаны дарга Д.Баярдорж, Нийслэлийн захирагчийн Ажлын албаны төлөвлөлт хариуцсан шинжээч Ц.Батгэрэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Энхжаргал, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн гэрээ, эрх зүйн мэргэжилтэн М.Уранбилэг, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр, мөн захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Ц.Баянмөнх, Б.Баярмаа, П.Хулан, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Б.Жаргалмаа, Г.Ганболд, Н.Энхболд нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Сарангэрэл, Н.Энхболд нар үг хэлэв.

Н.Энхболд: Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 43 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
9 цаг 26 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Гишүүдийн олонх хүрэлцэн ирлээ. Ирц бүрдсэн байна. Ингээд ТББХ-ны 2024 оны 5 сарын 3-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. ЗГ-аас 2024 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэнэ. 2 дугаарт, мөн ЗГ-ын 2024 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төсөл, түүнийг хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Нэг.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх хэлэлцүүлгийг явуулъя. Ажлын хэсгийг танилцуулчихъя. Ажлын хэсгээ оруулчихъя. Энэ 2 хуулийг хэлэлцэхэд оролцох ажлын хэсэг НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нямбаатар, НЗД-ын Эдийн засаг, дэд

бүтцийн асуудал хариуцсан Нэгдүгээр орлогч Сайнзориг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын шинжээч Төрбат, НЗДТГ-ын дарга Хосбаяр, Хосбаяр дарга ирсэн үү? БХБЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Бэлэгсайхан, мөн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын Хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ариунням, НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Цолмон, НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга Амгалан, НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Өрийн удирдлагын тасгийн дарга Эрдэнэбадрах, Алдаржавхлан Хан-Уул дүүргийн Засаг дарга, Хан-Уул, ирсэн байна уу? Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын дарга Батзориг, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Мөнхбаатар, энэ хүмүүс чинь хаачсан юм бэ Сайнзоригоо? Сайнзоригоо. Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Батбаяр, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны ерөнхий менежер Гүнболд, Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах хорооны Ажлын албаны дарга Баярдорж, хүмүүсээ дуудаарай. Өнөөдөр одоо хэрэв энэ дэмжигдвэл чуулганаар орно шүү дээ. Нийслэлийн Захирагчийн албаны Төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч Батгэрэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн Энхжаргал, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн гэрээ, эрх зүйн мэргэжилтэн Уранбилэг, НЗДТГ-ын хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Баялагцэнгэл. Ийм улсууд ажлын хэсэгт оролцож байна.

Тэр газрын албаны дарга, хүмүүсээ дуудаарай, Сайнзориг оо. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Амарсайхан танилцуулна. Амарсайхан сайдын микрофоныг өгье.

С.Амарсайхан: Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот байх, хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг ЗГ-ын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэхээр болсон. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлагын болон засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтоож, хот, тосгоны өөрийн удирдлагыг оршин суугчид нь сонгож, хот, тосгоны удирдлагад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын болон удирдлагын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв, санхүүгийн зарим эрх мэдлийг шилжүүлэх, удирдлагын давхардал, хийдлийг арилгах, хотын нийтийн үйлчилгээг оршин суугчдад төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, эдийн засгийн хувьд хот, тосгон харьцангуй бие даан хөгжих боломжийг бүрдүүлэх, шинэчлэн боловсруулсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд салбарын бусад хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлийг тус тус баримтлахаар заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Улаанбаатар хотыг амьдрахад таатай,

байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлэхээр 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогод аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутгийн төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжит хувилбарыг бүрдүүлэхээр тус тус зааж, хот, хөдөөгийн сэргэлтийг хангах зорилтыг тавьсан.

Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлт болон Монгол Улсын ЗГ Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хэрэгжүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон дагалдан гарах бусад хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулсан болно. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах үндсэн агуулга бүхий зохицуулалтуудыг тусгалаа. Үүнд, хотын өөрийн удирдлага нь хотын зөвлөл, хотын захирагч байх бөгөөд тэдгээрийг хотын оршин суугчдаас сонгоно. Ингэснээр оршин суугчид хотынхоо үйл хэрэгт иүүд сонгож байгуулсан төлөөллийн байгууллага болон төлөөлөгчдөөр дамжуулан оролцох боломжтой болох төдийгүй хариуцлагын тогтолцоо ч ойлгомжтой болно.

Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлсний үндсэн дээр хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэгэн адил төрийн үйлчилгээ болон нийтийн аж ахуйн иж бүрэн үйлчилгээг иргэдэд үзүүлэх боломж бүрдэж, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулан, тэгш хүртээмжтэй болгох юм. Хотын эдийн засгийн үндэс нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, түүнчлэн орон нутгийн өмч, татварын

болон татварын бус орлого, дэд бүтцийн сангийн болон бусад сангийн хөрөнгөөс бүрдэх ба хот нь эдийн засгийн хувьд бие даан хөгжих нөхцөлийг бүрэн хангана гэж үзэж байна. Хот, тосгод дүрэмтэй болж, хууль тогтоомжоор зохицуулагдаагүй хот, тосгоны амьдрал, үйл ажиллагаа, нийгмийн асуудалтай холбоотой зүйлийг оршин суугчдын оролцоотой шийдвэрлэдэг болно.

Хот бүрдүүлэгч инженерийн болон дэд бүтцийг хөгжүүлэх, дулаан, цахилгаан, холбоо, цэвэр, бохир ус, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний арчлалт, өргөтгөл шинэчлэлт, эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаанд зориулагдах санхүүжилтийг бие даан бүрдүүлэх зорилго бүхий хотын дэд бүтцийн хөгжлийн сантай байхаар тусгалаа. Хотууд нь хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчноо тохижуулах, авто замын түгжрэл, хог хаягдал, орчны бохирдлыг шийдвэрлэхэд иргэд, ААНБ-ын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ногоон хөгжлийн сантай байх юм. Хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Шинэ сэргэлтийн бодлогын хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогод нийцүүлэн Дархан, Эрдэнэт, Зуунмод, Шинэ Хархорин, Налайх, Багануур гэсэн улсын зэрэглэлтэй 6, орон нутгийн зэрэглэлтэй 34, дагуул 4 хотыг байгуулж, бие даан хөгжүүлэхээр төлөвлөлөө. 9 дүүрэг 204 хороотой.

Нийслэл Улаанбаатар хотыг 14 хот, 42 хороотойгоор шинэчлэн зохион байгуулж, 214 Засаг даргатай байсныг 4 дахин цөөрүүлэхээр мөн тусгасан болно. Ингэснээр чиг үүргийн төвлөрөл буурч, хотын оршин суугч амьдарч байгаа газраасаа 20 минутын газар, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн тээврийн үйлчилгээний буудал, цэцэрлэгт хүрээлэн, худалдаа үйлчилгээний болон бусад нийгмийн үйлчилгээг авах, авч байхаар 20 минутын хот стандарт төлөвлөлтийн концепцыг хэрэгжүүлэх боломж бүрдэж

байгаа юм. Стандарт 20 минут хот хэрэгжсэнээр иргэдийн төрийн үйлчилгээг авах, амьдрах орчноо сайжруулах боломж илүү бүрдэнэ гэж үзэж байгаа. Хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуух гишүүд нэрсээ өгье. Ганболд гишүүнээр тасаллаа. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Би Нийслэлийнхнээс асууя. 5, 6 асуулт байгаа, товчхон явчихна. 1 дүгээрт.../үг тасрав/

Н.Энхболд: Сайн бичиж аваад, нарийн хариулаарай.

Д.Тогтохсүрэн: Үндсэн хуулийн 57-гоосоо яаж тойрч байгаа юм бэ? Үндсэн хуулийн 57 дээр чинь нийслэл, дүүрэгт л хуваагдана гэж байгаа. Одоо энэ хуулиар 14 хотод хуваагдах гэж байна. Тэгээд Үндсэн хуулийн 57.1-ээ яаж тойрч байгаа юм бэ? Маши тодорхой хариулт. Монгол Улс их тодорхой шүү дээ. Нийслэлтэй холбоотой асуудал зөвхөн Нийслэлийн эрх зүйн байдлын хуулиараа, хот, тосгонтой холбоотой асуудал Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиараа. Эдгээрийг бүгдээрэнг нь нийлүүлээд засаг захиргаатай холбоотой асуудлаа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулиараа зохицуулж явдаг байхгүй юу. Энэ нийслэл чинь хот, тосгоноос өөр асуудал шүү дээ. Нийслэл хот хоёроо хольчихоод байгаа байхгүй юу нэг.

2 дахь нь аймгуудын би бол ингээж ойлгодог хүн, ЗГ хариулах байх гэж бодож байна барилга, хот. Аймгуудын төвүүдийг хот болгож байгаа нь болж байгаа юм. Тэгэхдээ аймгийн төвүүдийг хоттойгоо зэргэлдээ байгаа сумуудтай нь нэгтгэж хотоо байгуулж, эдэлбэр газрынхаа хэмжээг томруулах ёстой

юм. Аймгууд яагаад хөгжихгүй байна эдэлбэр газаргүйд байгаа юм. Эрдэнэт, Дархан чинь яагаад хөгжихгүй байгаа юм гэхээр эдэлбэр газаргүйд байгаа юм. Тэгээд эхэлж энэ эдэлбэр газартай холбоотой асуудлуудаа яаж авч үзсэн юм бэ гэдэг асуудлыг 2-т нь асуух гэж байгаа юм.

3 дахь асуудал нь. Бүтэц зохион байгуулалтын хувьд хотууд нь улсын зэрэглэлтэй хот ганцхан хороонд хуваагдах юм байна, улсын зэрэглэлтэй хот, тэгээд л хороотой, дунд нь нэгж байхгүй болж байгаа юм байна. Нөгөө дүүрэг гэдэг шиг юм байхгүй болчхож байна шүү дээ. Тэгэхээр энэ нөгөө Шарын гол нь ч юм уу, Орхон нь ч юм уу Дарханы, тэр Эрдэнэтийн нөгөө Улаан толгой, одоо энэ Жаргалант сум нь ч юм уу, тэр нь яаж явах юм бэ? Бүгд зүгээр л хороо болчих юм уу татан буугдаад.

Дараагийн асуудал, эрх шилжүүлэхтэй холбоотой асуудал. Эрх шилжүүлэх болбол ийм мэдээж улсын зэрэглэлтэй хотын тухайд бол бид нар ойлгож байна. Улсын зэрэглэлтэй хот болбол аймгаас тусдаа бие даасан эдэлбэр газартай энэ өөрөөр хэлбэл төвд харьяалагддаг ийм байна гэж ойлгодог улсын зэрэглэлтэй хотыг. Аймгийн зэрэглэлтэй хотууд аймагтаа харьяалагдах ёстой. Тэр яг энэ тэр агуулгаараа одоо орсон уу? Аймгийн зэрэглэлтэй хотуудыг тусад нь гаргаж болохгүй. Аймгийн зэрэглэлтэй хот бол яг л нөгөө аймагтаа л захирагдаж байх ёстой, орон нутгийн зэрэглэлтэй хотыг хэлж байна шүү дээ би.

Дараагийн асуудал нь байна шүү дээ эрх дээр байгаа юм. Би бодвол аймгийн, аймгийн эрхийг улсын зэрэглэлтэй хотод шилжүүлсэн байна гэж ойлгож байна. Тэгэх юм болбол сумын эрхийг орон нутгийн зэрэглэлтэй хотод шилжүүлсэн юм уу, одоо яаж шилжүүлсэн юм бэ? Сумын эрх чинь орон нутгийн шилжилтдээ орчихоор тэрнээсээ том байх ёстой байхгүй юу. Аймаг, сумын дундын эрх гэж гаргаж

ирсэн үү, энийг ер нь яаж шийдсэн юм, эрх шилжүүлэлттэй холбоотой асуудлыг?

Дараагийнх нь хэрэгжих хугацаатай холбоотой асуудал байгаа юм. Та нар хугацааг 25 оны 6 сарын 1 гэхихжээ. Бид хэрэв энийг ингээд баталъя, засаг захиргааны өөрчлөлт хийе, хотуудыг амилууля гэж бодож байгаа болбол энийг энэ зундаа хийх ёстой асуудал байхгүй юу. Намар болох орон нутгийн сонгууль буюу 10 дугаар сарын 11-нд болох аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуультай хот, тосгоны захирагч болон хотын зөвлөлийг хамтатган явуулж, энийг 4 жил нэг циклд нь оруулж өгөх ёстой байхгүй юу. Цикл зөрөх юм бол энэ ерөөсөө хэрэгжихгүй байхгүй юу. Энийг ер нь яагаад ингэж авч үзсэн юм бэ хугацааны хувьд нь?

Дараагийнх нь Хархорины тухай асуудал. Хархорин орон нутгийн зэрэглэлтэй хот болно гэж ойлгосон. Энд байхгүй байгаа юм. Шинэ Хархорум хот гэхээр улсын, тэр шинэ Хархорум хот чинь Хархориноос гадна Хашаат, Өгий нуур, Хархорин гэж 3 сумын нутаг дээр байгуулагдах юм. Та нар энэ дээр зөв биччихсэн байна лээ. Тусгай хэрэгцээнд авсан газраараа хотоо байгуулна гэж зөв. Гэтэл тэр тусгай хэрэгцээнд байгуулсан хот дотор чинь одоогийн байгаа Хархорин сумын төв нь болон ихэнх нь ороогүй юм. Гэтэл 15 мянган хүнтэй тэр орон нутгийн хотоороо үлдэхгүй сумаараа байх нь гэж ойлгож байна. Би их нарийн юмнууд асууж байна шүү.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн 9 цаг 43 минутаас хуралдааныг даргалав.

4 номерын микрофон ажлын хэсгийн.

П.Сайнзориг: Тогтохсүрэн даргын асуултад хариуля. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу засаг захиргаа,

нийслэл нь өөрөө засаг захиргаа нэгжийн хувьд дүүрэг, дүүрэг нь өөрөө хороодод хуваагдаж байгаа хэвээр байгаа. Бид энэ дүүргийн чиг үүрэг, дүүрэг дээрх дүүргийн засаг захиргааны нэгжийн энэ чиг үүргийг тус дүүрэг дээр байгуулагдсан хотуудад шилжүүлж гэж байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулиар бол зарим гэж үг байгаа. Зарим гэдэг өөрөө эргээд математикийн гэдэг юм уу, тоон талаасаа явах юм бол 99,9 хувь хүртэл шилжүүлж болно гэсэн үг. Тэгэхээр бид хэд бол энэ засаг захиргааны нэгж буюу дүүргүүдийн хэрэгжүүлж байгаа чиг үүргийг шинээр дүүргүүдийн нутаг дэвсгэр дээр байгуулагдах энэ хотуудад шилжүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд өгөх асуудал дээр бол Үндсэн хуулийн зөрчил байхгүй.

Өнөөдрийн энэ хууль болон Улсын Их Хурлын дагаж орж ирж байгаа хуулиудаар дүүргүүдийг татан буулгах гэдэг юм уу, өөрчлөх ийм асуудал ерөөсөө хөндөгдөхгүй байгаа. Нөгөө төвийн 6 дүүрэг хэвээрээ байна. Энэ дээр харин 14 хоттой болж байгаа. 14 хот дотроо энэ 6 дүүргүүдийн чиг үүргийг яг эдэлбэр газрынх нь хэмжээгээр шилжүүлж өгөөд, нэмэлтээр хот нийтийн аж ахуйн асуудлуудаа хариуцаад явах ийм байдлаар орж ирсэн Улаанбаатарын хувьд. Хөдөө орон нутгийн хувьд бол онцлог байгаа. Аймгийн төвүүдийн сумуудыг болон нэлээн төвлөрөл бүхий суурин газруудыг бол үндсэндээ орон нутгийн зэрэглэлтэй хот болгох, магадгүй заримыг нь тосгон болгож цаашидаа хөгжүүлэх бүрэн бололцоотой гэж одоо бид нар бас харж байгаа.

Эдэлбэр газрын хэмжээнүүдийг бол одоо бас тодорхой хэмжээнд одоогийн тэр жишээ нь сумыг орон нутгийн зэрэглэлтэй хот болгож хөгжүүлж байгаа бол яг тэр сумын газар нутгийн хэмжээгээр нь эдэлбэр газрыг нь тогтооё гэж өгч байгаа. Ер нь алсдаа эргээд эдгээрийн эдэлбэр газрын заагийг тогтоох асуудлыг нарийвчилж орж ирэх асуудлыг бас ЗГ-т чиглэл өгсөн байдлаар

Улсын Их Хурлын тогтоол бас гарч байгаа гэдэг зүйлийг бас хэлье.

Хотын хороо гэж байгаа. Хотын хорооны асуудал дээр жишээ нь Дархан-Уул аймгийн жишээг та авлаа. Дархан-Уул аймаг маань одоо Дархан сум, Шарын гол, Хонгор гэдэг энэ 3 сумаараа хамарсан байдлаар Дархан хот болж хувирна эдэлбэр газрын хэмжээгээрээ. Харин Дархан хот маань өөрөө улсын зэрэглэлтэй хот болж байгаа учраас улсын зэрэглэлтэй хот нь орон нутгийн зэрэглэлтэй хоттой байж болно гэж бид нар үзэж байгаа. Энэ дээрээ үзэх юм бол Шарын голыг бид нар жишээ нь дагуул хот болгоно гээд Улсын Их Хурлын тогтоол дээр биччихсэн байж байгаа. Бусад одоо суурин газруудыг бид нар тосгон хэлбэрээр хөгжүүлэх бололцоотой, эсвэл хотын хороо гэдэг байдлаар бид нар бас аваад явах бүрэн боломжтой гэж бид нар бас харсан. Энэ дээр хууль, эрх зүйн орчны хувьд ийм зүйл орсон байж байгаа.

Орон нутгийн зэрэглэлтэй хотын статус ямар байгаа вэ гэж байна. Энэ бол аймагтаа багтаж байгаа. Энийг бол ерөнхийдөө засаг захиргааны нэгжүүдтэй харилцах харилцаа, төсвийн харилцаан дээр илүү их тодруулж өгсөн байж байгаа. Өөрөөр хэлэх юм бол Дархан хот.../минут дуусав/

Д.Тогтохсүрэн: Нэмж минут өгье дөө. Чи нэмж хариулах юм уу? 4 номерын микрофоныг нэмж өгье.

П.Сайнзориг: Мааш товчхон хариулъя. Тэгэхээр Дархан-Уул аймаг тэр чигтээ Дархан хот болох юм бол Шарын гол гэдэг дагуул хот нь хамтдаа одоо төсвөө, төсвийн хязгаараа батлуулна гэсэн үг. Магадгүй Замын-Үүдийг орон нутгийн зэрэглэлтэй хот боллоо гэж үзэх юм бол Дорноговь аймгийнхаа төсөв дээрээ нэгдсэн байдлаар төсвийн хязгаар нь Улсын Их Хурлаас батлагдаж, орон нутгийн зэрэглэлтэй хот нь тухайн аймгийн Засаг даргадаа ерөнхийдөө бас дамжиж уялдаатай харьяалагдаж бас

үйл ажиллагаа явуулна гэж үзэж байгаа. Улсын зэрэглэлтэй хотуудын бас ялгаа нь эндээ байгаа.

Дээрээс нь энэ хэрэгжих хугацааны асуудал дээр та бас чухал юм асуулаа. Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийн шинэчилсэн найруулгыг бол дараа жилийн 6 сарын 1, Хот байгуулах Улсын Их Хурлын тогтоолыг нь бол 26 оны 1 дүгээр сарын 1-нээс гэж бид нар бас өгсөн. Энэ бэлтгэл ажлууд байгаа. 2 дугаарт одоо энэ улсын их, Орон нутгийн сонгуулийн хууль гэдэг юм уу, энэ яг хот, тосгоны захирагчийг, зөвлөлийн гишүүдийг сонгох энэ сонгуулийн асуудал бас нэлээн хүндрэлтэй буюу нэгэнт сонгуулийн цикл учруулсан учраас орон нутгийн сонгуулийг бас энэтэй холилдуулж юм уу, шинээр хууль батлаад зэрэгцүүлж явуулах боломжгүй байгаа. Бид нар дагаж мөрдөх журмын хуулиараа орон нутгийн сонгуулийн үр дүнг нэг удаадаа энэ хот, тосгоны захирагч болон зөвлөлийн эрхийг хэрэгжүүлэх энэ мандатыг олгож шилжүүлж өгч байгаа. Ингээд 28 он гэхэд ерөнхийдөө яг цэвэр хотуудын зөвлөл болон захирагчийн сонгуулиуд яг сонгодог утгаараа явна. Тэр болтол ямар ч байсан статусаа авъя, хуульд заасан чиг үүргүүдээ хэрэгжүүлье. ИТХ юм уу, сонгогдсон эдгээр чиг үүргүүдийг зөвлөл рүү, Засаг даргын чиг үүргийг захирагч руу гэдэг байдлаар шилжилтийн үеийн зохицуулалтыг бид нар хийж байгаа.

Хархорин хотыг бол орон нутгийн зэрэглэлтэй хот болгоход бол асуудал байхгүй. Зэрэгцүүлээд бас шинэ Хархорин, Хархорум хотуудыг бид нар улсын зэрэглэлтэй хот болгосон учраас энэ удаад бол хөндөөгүй. Тодорхой саналууд гарах юм бол одоо бас манай БХБЯ-наас бас хэлж байна. Дэмжихгүй гэхгүй, дэмжээд явахад өөрөө бүрэн бололцоотой байгаа юм.

Д.Тогтохсүрэн: Баярбат хариулах юм уу тэр бусад дээр нь, чи бол нийслэлээ л хариул гэнэ, чи тэр орон нутгийн юм мэдэхгүй байж хариулаад яах вэ. Тэр

нийслэлийн биш ээ тэр Барилга, хот байгуулалтын яам хариулах байх даа бодвол, тийм. Баярбат 7 номер.

Ц.Баярбат: Тогтохсүрэн гишүүний асуултад би бас товч хариулт өгье. 1 дүгээрт бол ер нь хуулийн төслийн 7.1 дээр байж байгаа. Хот нь хуульд өөрөөр заагаагүй бол ер нь оршин байгаа тухайн аймаг эсхүл нийслэлдээ харьяалагдана гээд. Тэгээд орон нутгийн зэрэглэлтэй энэ хотуудын хувьд бол бүгд аймагт харьяалагдаж, ингэж хотууд нь байгуулагдаж явна.

2 дугаарт тэр эдэлбэр газрын асуудлыг ярьж байгаа. Энэ бол засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгждээ харьяалагдаж байгаа учраас өөрөө бол яг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж шиг газрын хил зааг, эзэмшил, өмчлөлийг бол шийдвэрлэх ийм эрх байхгүй. Өөрийн эдэлбэр газрын хүрээнд үйл ажиллагаа явуулна. Эдэлбэр газрыг бол бид нар хот байгуулах шийдвэр гарсны дараа Газрын тухай хуулиар, Газрын тухай хуульд бол газрын ангиллуудыг зоочихсон байж байгаа. Энэ ангиллын нэг нь бол хот суурины газар гэсэн ийм ангилал байгаа. Энэ ангиллынхаа дагуу эдэлбэр газрын хэмжээнүүдийг тусгайлан тогтооно.

Тэгэхдээ 1 ийм асуудал бас Сайнзориг дарга түрүүнд хэллээ. Хэрвээ Дарханаар тогтооход Дархан, Эрдэнэт гэхэд өөрсдөө одоо бол яг газар нутгийн асуудалтай болчихсон байж байгаа. Тэгэхээр энэ эдэлбэр газрыг тусгайлан гаргаж тогтоохдоо энэ асуудлуудыг нь бол авч үзнэ гэж ингэж тооцож байна.

Мөн түүнээс гадна эдэлбэр газрыг тогтооход хот төлөвлөлтийн үүднээс бол ерөнхий төлөвлөгөө маш чухал. Тэгэхээр энэ ерөнхий төлөвлөгөөгөөр ирээдүйн 20 жилийн хөгжлийг төлөвлөсөн байдаг. Тэгэхээр энэ хөгжлийн төлөвлөлттэй нь уялдуулж эдэлбэр газрын асуудлыг тогтоох ийм чиглэлтэй байгаа.

Шинэ Хархорум, Шинэ Зуунмод хотын хувьд Улсын Их Хурлын тусгайлсан тогтоол гарч, хотуудыг байгуулсан учраас энэ дээр бол оруулж авч үзээгүй ингэж хуулийн төслийг боловсруулаад явж байна.

Д.Тогтохсүрэн: Би тодруулга асууя Сайнзоригоос. Одоо тэгээд ингэж явах юм уу Сайнзоригоо. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Сүхбаатар Сэлбэ хот гэж нэрлэх үү? Нийслэлийн СБД-ийн Сэлбэ хот, СБД-ийн Сүхбаатар хот гэж явах юм байна тийм үү? Өөрийн чинь ярьж байгаагаар.

2 дахь нь би энэ, бид нар нэг өөрчлөлт хийе гэвэл энэ өөрчлөлтийг хийчих ёстой байхгүй юу Баярбатаа. Бид нар олон жил ярьсан. Энэ аймгийн төвүүд чинь газаргүй учраас огт хөгжихгүй байгаа юм. Та нар ерөөсөө юм ойлгохгүй. Би бүр төслийг нь хийгээд та нарт өгчихсөн шүү дээ. Чи мэдэж байгаа. 25-аас 30 сумыг нийлүүлж байгаад маш гоё хот байгуулах тийм эрх зүйн орчныг бүрдүүлчих байхгүй юу. Энийг хийх гэж байгаа юм бол. Одоо байгаагаар бол наадах чинь огт газар байхгүй, хэдэн эдэлбэр газар нь дуусчихсан. Зэргэлдээ сумынхаа нутаг дээрээ газраа олгоод явж байгаа нэг хэдэн нөхдүүд л байгаа шүү дээ. Сайнзориг 4 номер.

П.Сайнзориг: Үндсэн агуулгын хувьд бол танд, та бас зөв ойлгож байна. Ерөнхийдөө тодорхой дүүргийн нутаг дэвсгэр дээрх хотууд байгаа. Гэхдээ хотыг өөрөө эргээд хэд хэдэн засаг захиргааны нэгж дамнуулж бас байгуулах бололцоотой. Бид энэ 14 хуваах асуудлыг яг одоо Сонгинохайрханыг 3 хуваагаад ч юм уу, Баянзүрхийг 3 хуваагаад хатуу тэгж хуваагаагүй. Аль болохоор тэр иргэдэд төрийн үйлчилгээ болон тэр хүртээмжтэй байдлуудыг нь бодолцож, эдийн засгийн бололцоог нь бас харгалзаж бас энэ хувааж байгаа.

Жишээ нь одоо яах вэ Хан-Уул дүүргийн зарим нутаг дэвсгэр эсвэл БГД-ийн зарим нутаг дэвсгэр жишээ нь Өнөр хороололд, Өнөр хотод орж ирж байгаа юм л даа. Тэгэхээр энэ нөгөө нэг төмөр замаараа наана, цаана байж байсан юмыг бид бас ер нь ингэж хуваах зохимжгүй. Засаг захиргааны хэд хэдэн нутаг дэвсгэр энд нь дамнаж байх учраас. Тэгэхээр ер нь зүгээр Улаанбаатар хот дахь 14 хот буюу Баянхошуу, Толгойт, Сонгинохайрхан, Буянт-Ухаа, Яармаг, Хан-Уул, Баянгол, Өнөр, Чингэлтэй, Сэлбэ, Дарь-Эх, ингээд Амгалан, Баянзүрх ч гэдэг юм уу ингээд явах юм. Харин энэ хотууд маань угаасаа 6 дүүргийн нутаг дэвсгэр дээр байгаа тэр чиг үүргийг нь авч хэрэгжүүлэх ийм төлөвлөлттэй байж байгаа, зохицуулалтаар хуулийг бичсэн байж байгаа.

Д.Тогтохсүрэн: Баярбатад хариулах юм байхгүй биз дээ. Орж ирээгүй юм чинь. 7 номер.

Ц.Баярбат: Таны хэлж байгаа асуудал маш чухал. Тэгээд бид нар бол ер нь энэ дээр бас түрүүнд Сайнзориг дарга ч хэллээ. Хэд хэдэн засаг, нутаг дэвсгэрийн нэгжийг дамнуулан хотыг байгуулах хууль зүйн үндэс нь бол байж байгаа. Тэгэхээр эхний ээлжид бид нар оруулж ирэхдээ бол ямар ч байсан аймгийн төв, хотуудын хувьд бол аймгийн төвийн сумыг татан буулгаж, хот болгох хэлбэрээр оруулж ирсэн. Цаашид бид нар энэ дээр бол газрынхаа яг хуулийг дагуулаад энэ эдэлбэр газрын хэмжээг тогтоох асуудлаа шийдэх нь зөв гэсэн ийм л байр суурьтай байсан.

Д.Тогтохсүрэн: Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Хуулийн энэ төслийг бол зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Ялангуяа нийслэл Улаанбаатар хотын хүн ам өнөөдөр зорчиж байгаа хүмүүстэйгээ ер нь хамтатгаад аваад үзэхэд сая 600 мянга хүрчээд байна гэсэн мэдээллийг саяхан хотын дарга өгч

байна лээ. Тэгэхээр хотод бол дорвитой бүр эрс шинэчлэл хийх цаг болсон гэдэг бол тодорхой байна. Харин одоо яг ингээд л Улаанбаатар хотод жишээлбэл гэр хорооллыг дэд бүтэцжүүлбэл, ингээд хэсэг, хэсэг төвүүдийг тойроод гэр хорооллыг хэсэгчилсэн инженерийн дэд төв болгоод хөгжүүлчихье гээд л ажил явах болохоор нөгөө газар доорх шугам сүлжээний асуудлууд, газар доорх ус, цэвэр усны шугамын асуудлууд гээд манай энэ хавь чинь бүүр тэр чигээрээ тийм цахилгааны утаснууд гээд ер нь энэ тал дээр маш тийм осолтой болчихсон юм байна лээ шүү дээ.

Тэгээд энийг бид нар эхлээд нөгөө дэд бүтэцээ, эрчим хүчээ шийдэж байгаад тэрнийхээ санхүүжилтүүдийг нь тусгаад, энэнийхээ дагуу ингээд цогцоор нь явна гэхгүй бол энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар аваад үзэхэд 26 оны 10 сарын, 1 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр байна. Хот, шинээр хот байгуулахтай холбоотой Улсын Их Хурлын тогтоол нь бас ингээд хэрэгжихээр байна л даа. 52 хотын зөвлөл, яам гээд ингээд явж байна. Хот доторх хотын асуудал яригдаж байна. Яг ийм хуулиар, яг ийм бүтэцээр, ийм эрх зүйн байдлаар аль улсад ийм хууль амжилттай амьдрал дээр хэрэгжиж чадсан бэ? Одоо яг Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг 2-ыг нэгтгээд 1 бүс болоод энэ дээр Сэлбэ дэд төвийг ашиглаад бусад Дэнжийн мянган төв юм уу ашиглаад ингээд хотууд байгуулъя гэхэд энэ чинь тэр 52 зөвлөл гэхээр сая та хэлж байна л даа. Дүүргийн газар нутаг дээрх хот дээр.

Тэгэхээр чинь нөгөө яг энэ тодорхой мэдээллийг өгөхгүй бол нөгөө богино хугацаанд оруулж ирээд, иргэдэд тодорхой мэдээлэл байхгүйгээс одоо ийм улс төр, нөгөө сонгууль дөхчихсөн болохоор сөрөг мэдээллүүд их явж байна л даа. Дүүргүүд татан буугдахын гэнэ, хороон засаг дарга нар, энэ хэсгийн ахлагч гэдэг байхгүй болоод, маш олон хүний ажлын байр цомхотгох юм байна

гэсэн жилийн дараагаас гэсэн нөгөө сөрөг PR нь хүртэл энийгээ дагаад яваад ирчхэж байна. Яагаад гэвэл нөгөө сонгууль дөхөхөөр бүх юмыг л нэг улс төрийн өнцгөөс юм уу хардаг шүү дээ. Тэгээд энэ өөрөө нөгөө ийм том, ийм чухал хуулийн ач холбогдол нь ингээд алга болчих, энэ нь өөрөө эргээд баахан нийгмийн шүүмжлэл дагуулаад явчих вий дээ. Тэгэхээр яг энэ дээр нь баахан нөгөө хуулийн төсөл маягаар ингээд ороод ирчихсэн.

Тэгэхээр маш тодорхой байх ёстой байхгүй юу. Түрүүн Тогтохсүрэн гишүүний хэлээд байгаа нарийн асууна шүү гэдэг шиг яаж тэр хот доторх хот маань өөрөө 10 мянгаас дээш хүн амтай гээд. Өнөөдөр ЧД гэхээр 103 мянга гээд үзье гэвэл 10 мянгаас гэхээр дотроо 2, Сүхбаатар, ЧД нийлээд дотроо хэд хэдэн хоттой болчихов? 20 минутын хот гэдэг маань өөрөө энийг хэлээд байгаа юм уу, эсвэл томоороо нөгөө хөгжүүлбэл гэдэг утгаараа энэ хууль маань орж ирж байна уу гэдгээ маш сайн тайлбарлахгүй бол аягүй жижиг, жижиг хотууд бий болчих, тэгээд баахан зөвлөл, хотын удирдлага, хотын зөвлөл гээд дахиад баахан бүтэц удирдлагын бүтцүүд бий болоод ингээд явчхаж байгаа юм шиг ийм ойлголтууд ингээд явчхаж байна л даа. Тэгэхээр бид нар эхлээд нэг хариултаа авъя. 1 дүгээрт Нийслэлийн орлогчоос.

2-т би БХБЯ-ны ТНБД-ын үүрэг гүйцэтгэгчээс асууя. БХБЯ-ны мэргэжилтнүүд яг хотыг, хот чиглэлээр мэргэжсэн хүмүүс энэ хуулийн төсөл дээр хэр сайн ажилласан бэ? Яг БХБЯ нь юуг нь хариуцаж, юун дээр нь оролцоо нь байх вэ, нийслэл Улаанбаатар хотын оролцоо нь энэ дээр яг юу байх вэ? Яагаад гэвэл энэ хууль гарвал жилийн дараагаас хэрэгжиж эхэлнэ. Хууль өөрөө энэ нөгөө Улаанбаатар хотыг, ялангуяа хүн ам ихтэй энэ Улаанбаатар хотыг эрс шинэчилж, эрс өөрчлөх асуудал бол угаасаа тулгамдсан асуудал болчихсон. Хүн амын хувьд ч, түгжрэл, энэ хөрсний бохирдол, агаарын бохирдол. Тэгэхээр энд тал дээр эхлээд мэдээлэл авчхаад,

дахиад тодотгоод асууя гэж бодож байна. Баярлалаа.

Д.Тогтохсүрэн: Ажлын хэсгийн 7 номер Баярбат дарга, дараа нь Сайнзориг.

Ц.Баярбат: Ер нь хотын одоо Монгол Улсын хувьд бол ийм л байгаа юм л даа. Нийт хүн амын 60 гаруй хувь нь яг хот суурин газарт оршин суудаг болчихсон. Олон улсын ер нь дундаж түвшинтэй харьцуулахад хот суурин руу шилжиж байгаа хүн амын шилжилт хөдөлгөөн нь 10 гаруй хувьтай болчихсон их, дэлхийн жишгээс бол их өндөр болчихсон. Тэгэхээр цаашид бид нар энэ нүүдлийн соёл иргэншил, суурин соёл иргэншлийг хослуулж авч явахад ялангуяа нийгмийн эдийн засгийн хөгжилд бол гол үүрэгтэй нь хот болчихоод байгаа юм. Тэгэхээр 1990 онд, 92 онд Үндсэн хуульд өөрчлөлт оруулахдаа өмнө бол засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хотыг тооцдог байсныг хасаад зөвхөн аймаг, нийслэл, дүүрэг, сум гэдгээрээ явдаг болчихсон.

Тэгэхээр энэ асуудал маань өөрөө энэ олон улсын, дэлхий нийтийн жишгийнхээ хөгжилтэй зөрчилдөөд эхэлсэн учраас энэ хот, тосгоны эрх зүйн байдлын асуудлыг тусгайлан авч үзэж, хотын энэ статусын асуудлыг цаашид яаж хөгжих вэ гэдгийг тодорхой болгох үүднээс энэ хуулийн төсөл дээр бол өөрчлөлт оруулж орж ирж байгаа. Ер нь 1993 онд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаас хойш энийг бол бид нар шинэчилж чадаагүй байсан.

Ер нь 2050 оны түвшинд дэлхийн нийт хүн амын 68 хувь нь яг ийм томоохон хот суурин газар амьдардаг ийм болж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ жишиг хөгжлийг дагаж энэ хотын асуудлаа бол тодорхой болгож, эрх хэмжээг нь тодорхой болгож, хөгжил цаашид явах вэ гэдэг эрх зүйн нөхцөлийг нь бүрдүүлье гэдгээр боловсруулсан ийм учиртай байгаа. Яамны хувьд бол ажлын хэсэгт хуулийн төсөлд бол санал өгөх

түвшиндээ бол оролцоод ингээд явсан байгаа. Одоо Засгийн газрын тухай хуулиараа бол хот, тосгоны хөгжлийн асуудал, орон нутгийн хөгжлийн асуудал бол ЗГ-ын Хэрэг эрхлэх асуудлын хүрээнд байдаг. Бид нар бол яг хот байгуулалт, төлөвлөлтийнхөө хүрээнд бол энэ үйл ажиллагаанд нь оролцоод ингээд явж байна.

Д.Тогтохсүрэн: Сайнзориг ажлын хэсгийн 4 номер.

П.Сайнзориг: Бид энэ хуулийн төслийг бас яах вэ боловсруулахдаа нийслэл болон ЗГХЭГ үндсэндээ төвлөрч суусан. Тогтохсүрэн нарын гишүүдийн анхлан боловсруулж байсан энэ хуулийн төслийг бас суурь болгож авч явсан. Тодорхой хэмжээний энэ засаг захиргааны нэгжийн чиг үүргийг хот руу шилжүүлэх энэ асуудал бас онолын түвшиндээ ч гэсэн яригддаг. Энэ онолын эрдэмтэн болох Бямбажаргал докторын бас энэ тайлбарууд дээр ч бас тодорхой байгаа. Тэгэхээр яг Оюунчимэг гишүүний асууж байгаа энэ асуудал дээр бол харьцангуй тийм проблем бол гарахгүй. Тодорхой хэмжээний мэдээж шилжилт хийх энэ юун дээр бол бэлтгэл ажлууд бол нэлээдгүй хийгдэнэ.

Энэ одоо юу гэдэг юм дүүргүүдийг татан буулгах гэж байгаа асуудал ерөөсөө байхгүй. Дүүргүүд хэвээрээ байна. Тэгэхдээ дүүргүүдийн чиг үүргүүд үндсэндээ хот руу шилжинэ гэсэн үг. Магадгүй ЧД-ийн чиг үүрэг бол тэр орчимд байгаа Чингэлтэй хот, Сэлбэ хот, зарим талаараа бол Баянгол хотын тодорхой хэсэг рүү ингээд шилжих ийм байдалтай ингээд явна. Энэ өнөөдөр бол үндсэндээ нийслэл Улаанбаатар хотынхоо жишээг ярихад 204 хорооны Засаг дарга, 9 дүүргийн Засаг дарга, 1 НЗД гээд 214 Засаг дарга ажиллаж байгаа юм. Яг эрх мэдэлтэй 10-хан Засаг дарга 9 дүүрэг, НЗД. Хороон засаг дарга маань эрх мэдэл байхгүй, төсөв байхгүй, хүний нөөц байхгүй. Иргэд анхан шатан дээр ороод асуудлаа ярихаар бид дамжуулъя гэж хэлдэг, дүүрэг рүү

уламжилъя, хот руу уламжилъя гэхээр иргэд бухимдаад байгаа юм. Тэгэхээр бид хэд энийг задалъя.

Ерөнхийдөө энэ засаг захиргааны нэгжийн чиг үүргээсээ гадна, хотууд эдийн засгийн хувьд бие дааж хөгжих, энэ хот нийтийн аж ахуйгаа бас авч явах энэ бололцоог нь бас хангая гэж байгаа юм.

2 дугаарт бас нэг үзэл санааны хувьд бол гэхээр Засаг дарга гэдэг бол үндсэндээ төрийн төлөөлөл талдаа буюу governor талдаа байгаа. Харин иргэд маань бол хотын даргаа сонгодог болъё, захирагчаа сонгодог болъё гэхээр энэ хот буюу тухайн тэр орон нутгийн эдэлбэр газрын хэмжээн дэх тэр хот суурин газрыг иргэдээс сонгогдсон захирагч сонгох энэ бололцоо буюу улс төрийн эрхийг нь бид нар иргэдэд өгч байгаагаараа энэ бас хуулийн том агуулга явж байгаа.

Улаанбаатар хот үндсэндээ Монгол Улсын цорын ганц хот болчихоод байгаа юм статусын хувьд. Тэгэхээр бид хэд цаашидаа улсын зэрэглэлтэй хотууд Дархан, Эрдэнэт гарах бололцоотой байна, Багануур, Налайх бололцоотой байна. Ингээд Төв аймгийн Зуунмод ч гэдэг юм уу ингээд өөрөө бие дааж хөгжих бололцоотой ийм хотуудаа бол дэмжээд явъя. Энэ ч гэсэн одоо энэ эдийн засгийн таталцыг бий болгох, энэ Улаанбаатарын төвлөрлийг сааруулах энэ чиглэлдээ бас нэлээн том түлхэц болно гэж бид нар бас үзэж байгаа. Энэ хүрээндээ бас энэ хуулийн төслийг боловсруулсан гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд яг бодит бас орон нутгийн зовлонг нь бол бас гишүүдэд зөвшөөрвөл Алдаржавхлан Засаг даргаас хариулъя. Яг орон нутгийн түвшинд хороодод буюу өнөөдрийн засаг захиргаа нэгжийн хувьд дүүргийн хэмжээнд жишээ нь үгүй ээ, нийслэлийн хэмжээнд жишээ нь юу болчихоод байгаа вэ гэдэг зүйлийг магадгүй дүүргийн Засаг дарга хүн илүү их надаас илүү хариулах байх.

Тогтохсүрэн дарга зөвшөөрвөл бас Алдаржавхлан даргаар маш товчхон л хариулуулчихъя.

Д.Тогтохсүрэн: Тодруулга Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Анхан шатад нийслэл Улаанбаатар хотын дүүргүүдийн зовлонг бол жишээлбэл би өөрөөрөө ярихад маш сайн ойлгоно. Асуудал маш их байгаа. Сая таны хэлж байгаа анхан шатад хорооны Засаг даргад ямар ч санхүүгийн эрх мэдэл байхгүйгээс болоод дүүргийн Засаг даргынхаа эрх мэдэлд хурууны үзүүрээр нь хөдөлдөг, хөдлөхгүй бол халагдчихна гэж айдаг, мөнгө өгч байна гэж дусаадаг, зүгээр гадаад, дотоод айлчлалаар авч явж нэг амыг нь тагладаг байдал одоо явж байгаа шүү дээ. Энийг таслан зогсоох ёстой 1 дүгээрт.

2-т та надаас, би сая асуулаа шүү дээ. Энэ хуулийн дагуу яг та нарын боловсруулж орж ирж байгаа энийг аль улсад амжилттай хэрэгжсэн бэ? Жишээлбэл, Сингапур, Хонконг энэ бол хот улс, өнөөдөр маш сайн хөгжсөн жишиг. Тэгвэл энэ хуулиар бол Сингапур шиг улсыг хэд хэдэн хот доторх хотууд болгож байж Чингэлтэй хот, Сэлбэ хот, Сүхбаатар хот, Өнөр хот гээд л ингээд л баахан хот болоод 52 зөвлөл гээд явчих юм байна лээ. Тэгээд энийгээ яг аль улсад хэрэгжсэн юм бэ? Ингээд явчихаар жилийн дараа энэ нөгөө дэд бүтцээ яах юм бэ? Эрчим.../минут дуусав/

Д.Тогтохсүрэн: Сайнзориг 4 номер.

П.Сайнзориг: Ер нь бол яах вэ, яг тэр улсын загвар бид нарт таарна, тэр ёстой хамгийн зөв хувилбар гэж одоо бол хувилбар бол байхгүй. Тухайн улсын онцлог, эдийн засгийн нөхцөл байдал, хүн амынх нь төвлөрөл, эргээд тэр ахуйн соёл ч байдаг юм уу энэ түүхэн цаг үеэсээ бас нэлээн холбогдож ярьж байгаа. Тэгэхдээ бид хэд уг асуудлуудыг бас авч үзэхдээ энэ ахуй соёлын хувьд болон ер нь

Ази mentality буюу энэ сэтгэхүйд таарсан бас энэ зүйлүүд рүү илүү их судалсан. Япон, Солонгос байна. Жишээ нь Японы хувьд бол үндсэндээ 730 гаруй хоттой юм байна лээ. Ерөөсөө ингээд яг энэ түвшиндээ хуваагддаг. Солонгос байна, province гээд бүүр аймгаасаа ингээд задраад доошоо ингээд явж байх жишээтэй. Тэгэхээр бид хэд энэ асуудал дээр ерөнхийдөө Япон, Солонгосын загвар авсан.

Хүн амын хувьд бол харьцангуй өндөр мөртөө 50 мянгаас дээшээ одоо төвлөрөл бүхий бүх сууринуудаа үндсэндээ хот болгож байна. Мэдээж хот болох шалгуурууд байна. Тухайн хотдоо нийт хүн амынх нь 50 хувь нь амьдардаг байх. Дээрээс нь 30-аас дээш хувь нь тухайн хотдоо ажиллаж, амьдардаг байх ч гэдэг юм уу иймэрхүү шалгууруудаар ингээд хотыг бий болгодог ийм зүйл байна.

Зөвлөлийг бол иргэдээсээ сонгодог. Тэгэхдээ нөгөө улс төрийн нам дэвшүүлж болдог, дэвшүүлж шууд улс төрийн намаас бус этгээдүүд дэвшидэг ч гэдэг юм уу янз янзын хувилбараар ингээд бусад улс орнууд харилцан адилгүй зохицуулж байгаа. Тэгэхээр цэвэр бид хэд бас яг энэ улсын практикийг шууд дагаж байгаа гэж хэлэхгүй. Мэдээж сайн практикуудыг нэлээн судалж, энэ тодорхой асуудлуудыг бас ингэж оруулж ирсэн гэдэг зүйлийг бас хэлье. Тэгээд Алдаржавхлан дарга нэмээд.

Д.Тогтохсүрэн: Доржханд гишүүн. Доржханд гишүүн асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд энэ хот суурин газрын эрх зүйн байдлыг тодорхой болгох асуудал орж ирж байна гэж ойлгож байна. Тэгээд 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх үед бид нар бас 5 тов тодорхой асуудал хөндөж ярьж байсны нэг нь бол энэ бол хотын асуудал юм. Зөвхөн Улаанбаатар хот биш Дархан,

Эрдэнэт, тэгээд цаашаа олон ийм хотууд байх хэрэгтэй байна гээд. Тэгээд харамсалтай нь бол энэ асуудал бол орхигдсон л доо.

Гэхдээ энэ ХҮН намын хувьд бол маш олон эдийн засагчид байдаг. Тэгээд бидний хувьд бол улс хөгжсө гээд тэгэх юм бол хүмүүсийн төвлөрөл үүсэж байж хөгждөг нэг тийм биз. Суурин газраа дагаж хөгжил бий болдог. 2 дугаарт аливаа улсад ямар хотууд байна гээд тэгэхээр тухайлбал нийслэл хот байна, нөгөө талдаа болохоороо аж үйлдвэрийн хот байна, худалдааны хот байна, логистикийн хот байна гээд ингээд ангилалтай. Тэгээд тэр нь газар зүйгээсээ хамаараад байдаг байхгүй юу. Тухайлбал, тээвэр логистикийн хот гээд тэгэхэд далайн худалдаа хийдэг, далайн боомттой улсуудын хувьд бол далайн эрэг дагуу байдаг. Далай байхгүй, хуурай газраар ингээд хүрээлэгдсэн улсын хувьд бол яг төв цэгтээ байдаг байхгүй юу. Төв цэгээсээ бусад тийшээ ингээд тараадаг нь эдийн засгийн үр өгөөжөөсөө болоод тэгдэг. Тэгээд худалдааны хот гэдэг чинь дандаа боомтууд дээрээ байдаг, аль эсхүл хил гааль дээр, нөгөө хилийнхээ орчимд ингээд байж байдаг.

Гэтэл манай тухайлбал Замын-Үүд гээд тэгэхэд өнөөдөр 20 мянган хүнтэй мөртөө хот биш, тэгээд сум ингээд явж байдаг. Гэтэл тэнд ингээд албан ёсоор хот байгаа байхгүй юу. Тэгээд Дархан, Эрдэнэт, тэгээд Хөтөл гээд л ингэхэд энд чинь бол нөгөө хөгжлийн алтан гурвалжин гээд л байдаг. Энэ чинь аж үйлдвэрийн хот байхгүй юу. Ийм байдлаар ингээд явах үнэхээрийн шаардлага бол байгаа юм. Ингэж байж улс орон бол хөгжинө, ингэж байж маш тодорхой эмх замбараатай болно.

Одоо асуулт байгаа юм. Бид нар бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гэдэг дээр нэгдээд, Улсын Их Хуралд суудалтай намууд бол хоорондоо зөвшилцөөд хөгжлийнхөө асуудлыг шийдье, тэгэх юм бол төвлөрөл үүсгэж

зах зээл үүсгэхийн тулд бүсчилье гээд ингээд орон нутгаа 7 бүсэд хуваасан. Тэгэхээр энэ 7 бүстэй маань яаж уялдаж байгаа билээ? Бүсүүдийн тулгуур төвүүд гэж байсан өмнө томъёолсон. Энэ дээрээ хотоо үүсгэх гээд байна уу, аль эсвэл аймаг болгон дээрээ та нар үүсгэнэ гэж орж ирж байна уу нэг?

2 дахь нь болохоор энэ Улаанбаатар хот гээд ингээд хот байдаг, маш том данхайчихсан. Нийт хүн амын яг ажлын зураг авалтаар 60-аас дээш хувь нь Улаанбаатар хотод амьдарч байгаа шүү. Маш их хязгааргүй эрх мэдэл хотын захирагч дээр байдаг. Тэгээд 9 дүүрэг дээр, тэгээд бусад нь эрх мэдэл байдаггүй бодитой үнэн. Тэгэхээр энэ эрх мэдлийг яаж хуваарилж байгаа юм бэ? Одоо би энэ Алдаржавхлан Засаг даргаас асуух гээд байгаа юм л даа. Уг нь бол ингээд гарч ирж байгаа үзэл нь бол зөв байгаад байгаа юм. Тэнд ингээд үр ашиггүй, жилдээ нэгхэн удаа ингээд, хоёрхон удаа уулзаад хуралддаг нэг ийм дүүргийн ИТХ байгаад байна 30-аас 40 гишүүнтэй. Тэгээд л өөр юм хийдэггүй. Тэгээд бүгдээрээ нэг дүүрэг дүүргийнхээ нэг орон нутгийн өмчит компаниудын захирал эсвэл ТУЗ-д нь ороод суучихдаг. Тэгвэл энийгээ больё, задалъя. Тэгээд нийслэлийн болоод дүүргийн эрх мэдлийг энэ жижиг хотууддаа өгье гэдэг энэ санал нь бол зөв юм.

Тэгэхдээ энэ дээр асуулт нь одоо энэ байдлаар хууль батлагдлаа гэхэд энэ дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлууд маань татан буугдана гэж ойлгож болох уу? Тэгээд хууль батлагдсан өдрөөс хэрэгжих гээд байна уу, тодорхой хугацаанаас хойш хэрэгжих гээд байна уу гэдэг.

Тэгээд дараагийн зүйл нь төсөв санхүүгийнхээ эрх мэдлийг та нар яаж өөрсөд дээрээ шилжүүлж авах билээ? Мөнгө байхгүй бол ямар ч ажил явахгүй шүү дээ. Тэгэхээр энэ төсвийн төвлөрлийг хотын дарга дээр байгаа асуудлыг, дүүргийн дарга дээр байгаа асуудлыг яаж шийдэх билээ. Тэгээд

хотын дарга, дүүргийн хотын.../минут дуусав/

Д.Тогтохсүрэн: Сайнзориг уу? Алдаржавхлан уу? Ажлын хэсгийн 5 номер.

Ж.Алдаржавхлан: Эрхэм гишүүний асуултад хариулъя. Энэ санаачилга бол ерөөсөө анхан шатаас гарч эхэлсэн. 1992 оны Үндсэн хуулийн одоогийн засгийн захиргааны нэгж бол одоо ажиллахад нэлээн хүндрэлтэй болчихоод байгаа юм. Хорооны Засаг дарга сая манай Доржханд гишүүн ярьж байна. Хорооны Засаг дарга гэдэг хүнийг сонгохын тулд маш том сонгууль болдог. Жишээ нь 20 мянган хүнтэй хорооны Засаг даргыг сонгохын тулд 420 айл тутмаас нэг хүн, ингээд 400 орчим хүн цуглаад нэлээн том улс төржссөн сонгууль болдог. Тэгээд ямар ч эрх мэдэлгүй хүнийг сонгохын төлөө бүгдээрээ дайрдаг. Тэгээд ялсан хүнийгээ эргээд шүүхдээд улс төрийн сонгууль болчихоод байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ хороонд байгаа улс төржилтийг 1 дүгээрт багасгая, тэгээд хорооны Засаг даргад эрх мэдлийг шилжүүлж гэдэг үүднээс энэ санаачилгыг гаргасан юм. 204 хорооны Засаг дарга өнөөдөр тэр гудамжныхаа лампыг ч солих эрх мэдэл байхгүй харанхуй гудамжныхаа. Тийм учраас бид нар хорооны 2-оос 3, 3-аас 4 хороодыг нэгтгээд, жишээлбэл Зайсангийн 2, 3 хороог нэгтгээд 1 Зайсан гэдэг хороо үүсгээд, тэр Засаг даргад нь эрх мэдлийг нь шилжүүлээд, Зайсан хавийнхаа жижиг сажиг бүх тохижилт, аар саар юмнуудаа бүгдийг нь тэр хүн өөрөө шийддэг. Хорооны Засаг даргад бид нар 95 хувийн эрх мэдлийг шилжүүлж өгье гэдэг саналыг гаргаж байгаа юм. Одоо хог тээвэр, хог тээвэр, муур нохой устгадаг чинь хотын дарга дээр байсан. Саяхнаас одоо бид нар дүүрэг рүү шилжиж ирж байгаа. Энийгээ тэр хороон дарга нь өөрөө асуудлаа шийддэг, дор, дор нь асуудлаа хариуцаад явдаг байхгүй бол иргэдийн ерөөсөө хамгийн

том бухимдал нь Засаг дарга гэхээр аймаар том хүн гэж боддог. Тэгээд очоод уулзахаар нөгөөх нь юу ч шийдэж чадахгүй байгаа болохоор л иргэд бухимдаад байгаа юм.

Тийм учраас бид нар хорооны Засаг даргыг эрх мэдэлтэй болгоё гэж байгаа. Дүүргийн иргэдийн хурлуудын эрх мэдлүүдийг хотууд руугаа шууд шилжүүлчихье л гэж байгаа юм. Үндсэн хуулийн нөгөө шинэ өөрчлөлтөөрөө. Хан-Уул дүүргийн иргэдийн хурлын эрх мэдлийг Хан-Уул дүүрэгт байгаа 3 хот руу шууд шилжүүлчихье. Тэгээд 3 хотууд нь одоо Доржханд гишүүн бас олон удаа ярьж байсныг нь би сонсож байсан. Ерөөсөө иргэд нь Засаг даргаа сонгодог байх ёстой л юм байна лээ. Иргэд нь тэр захирагчаа сонгодог байж, иргэд нь тэр захирагчтайгаа хариуцлага тооцдог байхгүй бол одоо бид нар тийм үү улс төржсөн, улс төрийн намаар дамждаг энийг бас татгалзаж, орчин үеийн дэлхий дахинтай бас хөл нийлүүлж алхъя гээд бид нар бас ийм санаачилгыг гаргаж байгаа юм.

Д.Тогтохсүрэн: Хорооныхоо даргад та нар эрхээ өгөөгүй байж, тэгээд хороо эрхгүй гэж ярьж болохгүй шүү. Та нарын л асуудал шүү дээ. Та нарыг тэр хот, тосгоны биш ээ, Нийслэлийн хууль орж ирэхэд нь би маш олон хэлсэн. Хороо чинь огт эрхгүй юм байна шүү дээ гээд, та нар тоодоггүй шүү дээ. Нийслэлээ томруулаад байна, нийслэлээ томруулаад байгаа мангас болоод л байна. Энэ чинь та нарын л асуудал шүү дээ. Сайнзориг 4, 4 номер. Одоо энэ хууль дээр ч гэсэн хороо чинь алга л байна шүү дээ.

П.Сайнзориг: Тогтохсүрэн даргын хэлж байгаа бас үнэн байгаа юм. Бид хэд одоогийн Засаг захиргааны нэгжийн тухай хууль болон Төсвийн тухай хуулиар яахаар нөгөө улсын төсөв маань шатлалын хувьд дахиад хороо гэдэг нэгж рүү буурахаар төсвийн ерөнхийлөн захирагч байх уу, байхгүй юу гээд асуудлууд бол байгаа. Тэгэх юм бол бүүр

Төсвийн хууль маань бүхэлдээ одоо тогтолцоо маань задрах ийм нөхцөл байдал байгаа. Тийм учраас энэ чиг үүргүүдийг нь бид нар хот руу шилжүүлье, хот нь доороо ганцхан нэгж буюу хотын хороотой байя. Ингээд эрх мэдлийг нь өгье гэж байгаа.

Тогтохсүрэн даргын бас энэ алдаануудыг бас хэлж байгааг засаад бид нэгжийн хууль дээрээ 26 дугаар зүйл дээр нь хороонуудад нэлээн олон чиг үүргүүдийг өгч байгаа. Энэ нь бас яг нэгжийнхээ чиг үүргийн хувьд хотын хороо руу бас давхар шилжинэ. Тэгэхээр энэ хороо бол улс төржих цэг биш. Энэ бол хот нийтийн аж ахуй буюу хог шороогоо цэвэрлээд, иргэдийнхээ ойр зуурын тэр сэтгэл ханамжийг бүрдүүлээд явж байх ёстой нэгж байгаа.

2 дугаарт энэ бүсийн төвүүд бол бүгд хот болж байгаа. Энэ алсдаа харин бүсийн төвүүдийг улсын зэрэглэлтэй хот болгох уу, үгүй юү гэдгийг бол Улсын Их Хурал явц дундаа Эдийн засгийн хөгжлийн яамны саналын дагуу шийдэх нь зөв байх гэж бид нар үзсэн. Мэдээж энэ тодорхой хот гэдэг бол эдийн засгийн бүтэцтэй буюу орлогын эх үүсвэр, татварын бааз суурьтай байх ёстой. Жишээ нь Налайхыг бид нар бол үндсэндээ тээвэр логистикийн төв болон барилгын материалын үйлдвэрлэлийн дагуу хөгжиж чадах бие даасан хот байж чадна гэж үзэж байгаа юм. Улаанбаатарт байгаа баян, 320-оод энэ салаар төмөр замыг дагасан тээвэр логистикийн төвүүдийг бид нар Налайхын Баян өртөө рүү гаргая, баруун талыг нь Хөшигтийн хөндий рүү гаргая гэж байгаа юм.

Хөшигтийн хөндийн маань агаарын тэр терминалтайгаа Богдхан төмөр замаараа холбогдоод авто тээврийн замаа юугаар холбогдох юм бол иж бүрэн одоо юу гэдэг юм тээвэр логистикийн hub болж хөгжих бас бололцоотой. Өнөөдөр Эрэнээр орж ирж байгаа бүх бараа бүтээгдэхүүн нь Улаанбаатарт орж буугаад 21 аймаг руу

задарч байгаа. Энэ ч өнөөдөр бас Улаанбаатарын эрсдэлтэй байдлыг ч нэмэгдүүлээд байгаа юм. Улаанбаатарт 220 мянган тэсэрч дэлбэрэх бодис буучхаад 21 аймаг буюу уурхайн бүс рүү ачигдаж байгаа шүү дээ. Ямар ч шаардлагагүй эд зүйл. Тэгэхээр энийг бид хэд одоо бусад хотууд руугаа энэ зах зээлд тэр эдийн засгийн хуваарилалтыг бас зөв хийе. Энэ бол ингээд Налайх Баян өртөөн дээр ингээд аваад явчих бололцоотой. Энэ одоо чиг үүрэг байна л гэж бид нар жишээ нь хараад явж байгаа. Тэгэхээр яг л ийм байдлаар хотын асуудлуудыг илүү их эдийн засгийн хувьд бие дааж хөгжих тэр бололцоогоор нь бас хувааж хөгжүүлэх чиглэлд нь бас анхаарч байгаа гэдэг зүйлийг бас хэлье.

Хууль маань бол 25 оны 6 сарын 1-нд байгаа. Тогтоол маань бол 26 оны 1 сарын 1 байж байгаа. Тэгэхээр энэ одоо яах вэ зүгээр намрын орон нутгийн сонгуулийн үр дүнг цаашидаа бас нэг удаа зөвлөл болон захирагчийн үр дүнг хүлээн зөвшөөрч явах, тэгээд 28 оноосоо бол яг сонгодог утгаараа захирагч болон зөвлөлөө сонгоод явъя. Тэр болтол бид нар бас шилжилтийн болоод бас энэ юмнууд явагдах ёстой гэж бид нар бас харсан. Ийм байдалтай ингээд явж байгаа.

Д.Тогтохсүрэн: Доржханд гишүүн тодруулга нэг минут.

Т.Доржханд: Тэгэхээр энэ шинэчлэлтээ хийвэл зоригтой хийх хэрэгтэй шүү. Зоригтой хийх хэрэгтэй. Тэгээд одоогоос хийх хэрэгтэй. Бид нарын тооцооллоор яг улс төрийн албан тушаалтан, сонгуульт албан тушаалтан хэд байна вэ гэхээр 10800 хүн байгаа юм. Үүн дотор бол дүүргийн иргэдийн төлөөлөгч, тэгээд сумын иргэдийн төлөөлөгч гээд. Тэгээд дүүргийн ИТХ-ын гишүүд нь юу хийж байна вэ гээд тэгэхээр жилдээ 2, 3-хан удаа төсөв баталдаг. Тэгээд л өөр ажил хийхгүй байна шүү дээ. Ямар ч эрх мэдэл байхгүй, юу ч хийдэггүй. Тэгээд л нэг дүүргийн төрийн өмчийн компаниуд дээр

очоод л захирал болоод суучихдаг. Одоо ийм үргүй зардлуудыг чинь санхүүжүүлмээргүй байна шүү дээ. Гийм биз дээ? Үгүй ээ, тэгвэл энийгээ одоо шийд л дээ, зоригтой шийд л дээ, хурдан шийд л дээ. Хууль батлагдсан өдрөөсөө шийдмээр байна.

Ингээд хотынхоо дарга нарыг иргэдээсээ шууд сонгодог байх ёстой. Ингэж байж энэ намжилт, талцал хуваагдлыг бид нар засах ёстой юм. Ингэж байж бид нар дэлхийн жишиг рүүгээ ойртох ёстой юм. Ийм болохоор хугацаагаа наашлуулах.../минут дуусав/

Д.Тогтохсүрэн: Санал хэллээ. Ганболд гишүүн.

Г.Ганболд: Нийслэлийнхэн юм хийх гээд л оролдоод л гүйгээд л байна. Уг нь дэмжмээр л байх юм. Тэгээд энэ чинь 25 оноос гээд тэгээд ер нь бол 28 оноос юм болбол энийг бачимдаж өчигдөр өргөн бариад л, өнөөдөр уншихын эцэсгүй 100 гаруй хуудас юмыг чинь харахгүй байна шүү дээ, энэ чинь дагасан хуулиуд нь ч маш их. Тэгээд түрүүний Тогтохсүрэн гишүүний хэлсэн Үндсэн хуулийн 57-гоос бол яагаад ч та нар зайлахгүй шүү дээ. Одоо тэгвэл нийслэл нь дүүрэгт хуваагдахаар дүүргүүдийн чинь иргэдийн хурлын сонгууль болдгоороо болоод, дүүргийн иргэдийн Хурлын дарга, Засаг дарга нь байх юм байна шүү дээ. Тэгээд дотор нь дахиад хотын дарга нар гэж байх юм уу, дүүрэг нь байх юм уу, дүүргийн хурал нь.

Тэгэхээр уг нь болбол саяын хэлсэн тэр хороо татан буулгаад 5, 10 хороог ч хамаагүй нэгтгээд тэр Хан-Уул хот гэдэг нэртэй болно уу, тэр зохион байгуулалт нь бол иргэдийн хуралд бүрэн байгаа шүү дээ татан буулгах, нэгтгэх. Тэгээд ийм замаар явчихгүй заавал одоо ингээд л хот болгоод л энд чинь тэгээд л хаяг шошго, иргэний үнэмлэх, үл хөдлөхөөс өгсүүлээд л ингээд л асар их дарамтууд хүмүүст орохоор байх юм. Тэгээд өнгөрсөн 7 хоногт чинь бид нар байна шүү дээ энэ нэгжийг татан

буулгах, шинээр байгуулах юм болбол заавал иргэдээс санал авах журам гээд баахан журам баталчихсан. Одоо энэ дүүргүүдийг чинь татан буулгах юм уу, шинээр байгуулах юм болбол заавал тэр журмаар явмаар байх юм.

Тэгээд маш олон хуулиуд дагаж орж ирсэн байна. Энэ хуулиуд нь бас л одоо энэтэйгээ зэрэгцээд 28 оноос хэрэгжих үү, хэзээнээс хэрэгжих юм, эсвэл энэ дагасан хуулиудаа л гол оруулж ирэх шалтгаан байсан юм уу? Энэ дагасан хуулиуд дээр чинь энэ газар, тусгай хамгаалалттай газар нутаг, энэ Богд уулыг чинь тэгээд л бүгдээрэнгийнх нь эрх мэдлийг л авах зорилго л агуулаад байх шиг л байх юм. Ер нь болбол.

Тэгэхээр байна шүү дээ энэ сонгуулийн юмнуудыг яах юм бэ? Сонгуулийн хуулиуд. Сонгуулийн хуулиар чинь одоо энэ хотын шинээр байгуулагдах нэг хотын зөвлөл даргыг байгуулах хууль нь дахиж шинээр орох юм уу? Тэгэхээр зэрэг энэ дээр ерөөсөө маш их зөрчилтэй юмнууд байгаад байх юм. Одоо ингээд Дархан-Уул аймаг чинь тэгээд хэрэв Дархан хот гээд хот болчих юм бол Дархан-Уул аймаг татан буугдмаар. Дархан-Уул аймаг байх юм бол Дархан-Уул аймгийн иргэдийн хурал нь байж байх уу, Засаг дарга нь байх уу, дотор нь дахиад Дархан хотын зөвлөл байх уу, Дархан хотын захирагч нь байх юм уу ингээд энэ чинь ерөөсөө утгагүй юм болох гээд байх юм.

Тэгээд сая Хархориныг байгуулж болно гээд чи хэлж байх шиг байна. Тэгсэн хэр нь энэ чинь ийм байх юм. 30-аас доошгүй мянган оршин суугчтай гэж байгаа юм. Эсвэл оршин суугчтай байхаар төлөвлөсөн гэхээр энэ чинь томоохон нэг 10-аад мянган хүн амтай сумууд чинь ингээд 30 мянган хүн байна гээд бүгдээрээ нэг төлөвлөчихсөн нэг зураг зурчихсан юмнууд байгаад байх юм. Тэгэхээр Өвөрхангайн Хужирт ч юм уу, Бат-Өлзий эд нар манайх 30 мянгаар төлөвлөчихсөн байгаа хот болъё гэвэл яг яах вэ. Тэгээд гэх мэтчилнээр ерөнхийдөө

ингээд зөрчилтэй юмнууд их байна, Сайнзориг даргаа.

Тэгээд Тогтохсүрэн даргаа энийг яг өнөө өглөө орж ирээд би энэ 100 хэдэн хуудас юмыг надад ерөөсөө уншихын ч эцэс алга. Тэгээд энийг нэг жаахан түр хойшлуулаад нэг жаахан хэлэлцүүлгийн түвшинд нэг явуулбал яасан юм бэ даргаа? Бүлгээр ярьдаг юм уу, эсвэл нэг хэлэлцэхээ нэг түр хойшлуулаад, тэгээд 1 бас нэг бид нар чинь унших боломжуудыг нь бүгдийг нь нэг хармаар байна шүү дээ. Тэгэхгүй бол энэ чинь маш том хуулийг ингээд сүүлд нь энэ чинь нийслэл чинь дагаад бужигнаад, нэгжүүд нь өөрчлөгдөөд дагаад иргэдэд маш том хүндрэл бэрхшээлүүд учирна. Би түрүүн хэлсэн хаяг байриллаас өгсүүлээд л, тэгээд л асар их юм болмоор юм шиг л байх юм. Тэгээд энэ дээр нэг ямар ч гэсэн би нэг хариулт аваадахъя даа.

Д.Тогтохсүрэн: Хариулт Амарсайхан сайд өгөх юм уу? Амарсайхан сайд, дараа нь хэдэн номер юм бэ? 4 номер. Амарсайхан сайдын микрофоныг өгье.

С.Амарсайхан: Ганболд гишүүний хэлж байгааг бас ойлгож байгаа. Мэдээж энэ нэгжийн хуваарилалтыг өөрчлөх, хууль дүрэмд өөрчлөлт оруулах, амьдралд нийцүүлэх гээд цаг хугацаа шаардсан, зохион байгуулалт хэрэгтэй мэргэжлийн зөвлөмж, зөвлөгөө, шаардлагатай асуудлууд их бий. Тэгэхдээ энийг одоо хойшлуулах нь зохимжгүй гэж үзэж байгаа. Байнгын хороогоороо хэлэлцэх асуудлаа хэлэлцчихээд ажлын хэсэг байгуулагдана. Ажлын хэсэг дээр асуудлууд яригдаж, дахин эцэслэгдэх учраас тэрэн дээр саналаа өгөөд, тэгээд магадгүй оролцоод явах нь илүү зөв байх гэж бодож байгаа 1 дүгээрт.

2 дугаарт энэ асуудлыг бол энэ чуулганы бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлуулах нь хамгийн зөв. Одоо бид нар чинь 21 аймагтай, 1 нийслэл хоттой. Нийслэл хотынх нь ЗДТГ төв талбайнхаа хажууд. Өнөөдөр

нийслэл хотод амьдарч байгаа гэж байгаа боловч хот хөдөө нь мэдэгдэхгүй, хотын мэдрэмжээ ч авч чадахгүй, хотын статустайгаа ч мэдэхгүй, хот хөдөө нь ч ойлгогдохгүй ийм газар энэ нийслэлийн ЗДТГ тэр Баянхошуунд байгаа, тэр Налайхад байгаа, тэр Багануурт байгаа хүмүүст шаардлагатай нийгмийн дэд бүтэц, аюулгүй байдал хангагдсан орчин, тэгээд бие дааж хөгжих боломж нөхцөл, төрийн үйлчилгээ, дэд бүтцийн асуудлууд, хог хаягдал, хот нийтийн аж ахуйн ажлууд гээд бүгдийг нь хүргэхэд ямар ч боломжгүй болчихоод байгаа юм. Тийм учраас энэ хотын статусаа одоо түргэн шуурхай шийдвэрлэе гэж.

Тэгээд энэ хот болсноор болбол оршин суугчид орон нутгийн захиргааны үйл ажиллагаанд хамрагдах, өөрсдөө оролцох, тэгээд үйл явцыг нь тодорхойлох, хөрөнгө оруулалт татах, хоорондоо өрсөлдөх, өөр өнгө төрхтэй хөгжих тийм боломж нөхцөл нь бүрдэх юм байгаа юм. Одоо ингээд 9 дүүрэгтэй. Дүүрэг бие дааж дүүрэгтэй хөрөнгө оруулалт татах тийм боломж огт байхгүй байгаад байна. Хөрөнгө оруулалт татах боломж байхгүй учраас ажлын байр бий болохгүй, ажилгүйдэл, ядуурал буурахгүй. Ингэж бие дааж хот болсноор энэ өөрсдөө хөрөнгө оруулалтаа ч татах, төсвөө ч бүрдүүлэх эрх зүйн орчноо ч бүрдүүлэх, хот, дүүргүүд, орон нутгууд хоорондоо бие дааж хөгжих, өрсөлдөх боломж нь бүрдэж байгаа зах зээлийнхээ зарчмаар. Тэгээд тэр эрх мэдлийн хуваарилалтыг хийх.

Энэ хотын асуудал болбол анх удаа яригдаж байгаа юм биш л дээ. Би Иргэдийн хурлын төлөөлөгч байхдаа өргөн барьж, Бат-Үүл даргын үед Налайх, Багануурыг дагуул хот болгоё гэж шийдвэрлэсэн. Харамсалтай нь цаашаа яваагүй. Яагаад гэвэл төсвийн бие даасан эрх мэдэл байхгүй, хууль эрх зүйн орчин бүрдээгүй. Гэхдээ энэ болбол бас хэдийгээр сайн болоогүй ч гэсэн том туршлага болсон. Одоо ингээд бие даасан хот болгоод явж байж бид

иргэдэд хүрч чадахгүй байгаа тэр үйлчилгээг хүргэх, зам, сургууль, дэд бүтэц, цэцэрлэгт хүрээлэн өөр юу байдаг юм тэр бусад байх ёстой оршин суугчдын амьдралын чанарыг сайжруулахад шаардлагатай бүх үйлчилгээг түргэн шуурхай хүргэх ийм боломж нь бүрдэх юм. Тэгэхдээ ажлын хэсэг бас энэ дээр.../минут дуусав/

Д.Тогтохсүрэн: Ажлын хэсгийн 4 номерын микрофон Сайнзориг.

П.Сайнзориг: Ганболд гишүүний бас санаа зовж байгаатай бас ойлгож байна. Яах вэ зүгээр хуулийн төслийн хувьд бол эцэслэсэн хувилбар нь яах вэ тулгуу орж ирсэн. Тэгэхдээ сая бас Шадар сайд бас хэллээ. Энэ бол бас өчигдөр яригдаад, өнөөдөр шийдэх гээд байгаа зүйл биш. Мааш олон жил ярьсан. Тогтохсүрэн даргаар ахлуулсан ажлын хэсэг бас олон жил ажилласан. 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөс хойш л тал талын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгүүд явж байгаа. Бас гадаад улсын туршлагауудыг ч нэлээн судалсан. Эрдэмтэн судлаачдын бас энэ өөр өөрийн байр суурь, энэ бүх зүйлүүд бас ингээд энэ асуудал их олон жил яригдсан.

Тэгэхээр бас тодорхой хэмжээнд одоо шийдэх цаг нь болсон юм болов уу л гэж одоо бид бас ойлгож, энэ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, эргээд энэ Улаанбаатар өөрөө нэг бүс болж байгаагийн хувьд засаг захиргааны шинэчлэл гэдэг юм уу, энэ эрх мэдлийг задалж, төрийн үйлчилгээг иргэддээ ойртуулахгүй бол бас болохгүй байна гэдэг зүйл бол одоо бас эцсийн дүндээ бас яригдаад энэ асуудлыг ингээд оруулж ирж байгаа. Нэг ч өөрчлөгдөөгүй. Жишээ нь Улаанбаатарын хувьд бол 6 дүүрэг маань хэвээрээ байна. 6 дүүрэг, ер нь энэ удаагийн намрын сонгууль бол болдгоороо болно. Энэ иргэдийн хурал нь л шилжинэ, байхгүй. Үндсэндээ энэ чиг үүрэг хот руу шилжчихэж байгаа байхгүй юу. Тэгээд л хотын зөвлөлөө сонгоод явах ийм асуудал байгаа.

2 дугаарт яах вэ тэр хаяг address-ийн хувьд өөрчлөлт бол байхгүй. Иргэний үнэмлэх дээр жишээ нь хаяг бичихээ болиод одоо бараг 3, 4 жил болж байгаа. Энэ бүгд нөгөө цаанаа нөгөө цахим мэдээллийн санд ороод явчхаж байгаа. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээнүүдийг бид нар цахимаар олгодог болчихсон, цахим гэрчилгээтэй болчихсон. Хүндрэлүүдийг бол бид нар бас тооцож, бас аль болохоор иргэд, ААНБ-д зардал багатайгаар бас энэ шилжилтийг хийе гэж одоо бодож байгаа. Ер нь бол хаяг address-ийн хувьд бол боломжтой.

Эргээд одоо яах вэ, зүгээр хот болгох уу, үгүй юү гэдэг тодорхой суурин газрыг хот болгох уу, үгүй юү гэдэг Улсын Их Хурлын бүрэн эрх байгаа. Түүнээс биш хууль гаргаад л 30 мянган хүнтэй суурин болгоныг бас хот болгохгүй. Ийм л одоо концепцтой. Эцсийн шийдэл бол Улсын Их Хуралд бүрэн эрх нь хадгалагдаж байгаа гэсэн үг. Энэ хүн амын төвлөрөл, эдийн засгийн боломж, эргээд бие даан хөгжих бололцоо зэргийг нь харгалзаж байж Улсын Их Хурал шийдэх юм байгаа юм.

Д.Тогтохсүрэн: Гишүүд, Ганболд гишүүн тодруулга нэг минут. Ганболд гишүүний микрофон.

Г.Ганболд: Одоо ингээд ард нь хуваачихсан юм байна шүү дээ энэ хотуудыг чинь бүүр координатаар нь энэ дээр чинь одоо хуваагаад оруулаад ирсэн юм байна шүү дээ. Тэгээд эд нар чинь одоо яг бие даагаад өөрөө санхүүжилтээ бүрдүүлэх яг хууль, эрх зүйн орчин чинь байхгүй л байгаа. Яг нарийн ярих юм болбол энэ төвийн нэг жаахан үйлчилгээний газрууд, үйлдвэр хоршоо ихтэй дүүргүүд нь арай нэг дээр байж магадгүй. Алслагдсан гэр хорооллынхон болбол бие даагаад явах ямар ч боломж байхгүй шүү дээ. Үгүй ээ, нийслэл л өөрөө иргэдийн хурал нь тэр дүүргүүддээ ахиухан төсвийг нь ингээд л хуваагаад л өгчхөөч.

Тэгээд л дүүргүүд нь тэр хороонуудаа нэгтгээд, 10 хороог нийлүүлээд дунд нь гоё нэр тэр хот гэдэг юм уу, юү гэдэг юм нэр өгөөд л 20 хороог ч юм уу нийлүүлээд л, тэгээд л нэг хот нэртэй юм болгоод л төсөв өг л дөө Алдаржавхлан. Та нар өөрсдөө хороондоо нэг ч төсөв өгөхгүй болохоор чинь тэд нар яаж хөгжих юм бэ? Хамаг юмыг нь та нар өөрсдөө эндээ төвлөрүүлж авч хэвтчихээд л байгаад байгаа шүү дээ.

Д.Тогтохсүрэн: Санал хэлчихлээ. Санал хэлсэн, асуулт гараагүй. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо хуулийн төсөлтэй холбогдуулж санал хэлэх гишүүдийн нэрс авъя. Үг хэлэх гишүүн байна уу? Амарсайхан гишүүн үг хэлэх юм байна. Минийх чинь тэнд байгаа билүү? Би. Амарсайхан сайд үг хэлнэ гэж байхгүй шүү дээ хууль санаачлагч.

С.Амарсайхан: Гишүүний хувьд хэлчихье дарга, тийм. Яах вэ, зүгээр одоо хороодод төсөв шилжүүлнэ гэхээр яах вэ хэлэхэд их амархан байгаа юм. Хууль, эрх зүйн хувьд хорооны Засаг дарга нар төсөвт захиран зарцуулах асуудал бас одоо хязгаарлагдмал байгаа юм. Хорооны Засаг даргад төсөв өгөөд тэгээд бас тэр төсвийг үр өгөөжтэй яаж зарцуулах вэ гэдэг асуудал ойлгомжгүй байгаад байгаа юм. Хот төлөвлөлт, дүүргийн зохион байгуулалт, хот нийтийн аж ахуйн ажлууд гээд. Тэгээд яах вэ одоо бид нар ингээд энэ асуудлуудыг хэлэлцэхгүй байлаа гэхэд орон нутаг ч тэр, Улаанбаатар ч тэр бахь байдгаараа л байна.

Өөрөөр хэлбэл, өнгөрсөн хугацаанд хумигдаж, хумигдаж 21 аймгаасаа нүүх нь нүүгээд, ирэх нь ирээд хотынхоо төвд энэ 30, 40 га газар дээр бүгд төвлөрөөд хумигдсан ийм бодлого явсан болбол уг нь бүсчилсэн хөгжилтэйгөө уялдуулаад шинэ Хархорин, тэр хуучин Хархорин ч гэнэ үү, тэр Багануур, Налайх, Багахангай, Дархан, Эрдэнэт, Шинэ Зуунмод гээд

ингээд тэлж хөгжих боломж өөрөө бүрдэж байгаа юм. Тэр тэлж хөгжих бодлогын хүрээнд яг тухайн, тухайн орчиндоо иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх тэр эрх зүйн орчныг нь төсвийн бие даасан байдалтай нь Улсын Их Хурлын хууль тогтоомжоор нээж өгөхгүй болбол нийслэл, орон нутаг, аймаг аль нь ч бай шууд тэр зохион байгуулалтыг хийгээд явна гэдэг өөрөө хууль, эрх зүйн хувьд ч боломжгүй, эдийн засгийн эх үүсвэрийг бүрдүүлэх тал дээр ч боломжгүй.

Тэгэхээр татвар хураамж, тэгээд одоо төсөв бүрдүүлэлт, хөрөнгө оруулалтыг татах сан гээд. Хамгийн зөв бас нэг үр дүнтэй ажил болбол энэ бие даасан болон дагуул хот болсноор хоорондоо эрүүл өрсөлдөх боломж үүсэж байгаа. Өнөөдөр манай 9 дүүрэгтэй нийслэл, аймгууд сумтай, хоорондоо ижил төсөвтэй, төсвийн татаастай, тэгээд бие дааж бодлого гаргах эрх нь ойлгомжгүй, тодорхойгүй татвараас эхлээд бүх зүйл. Ингээд өрсөлдөөн ерөөсөө байхгүй байна шүү дээ. Энд байгаа Баянзүрхийн амьдрал, тэнд байгаа Сонгины амьдрал яг ялгаагүй. Ямар ч ялгаагүй гудамж зам, тэр хог, ноши, эсвэл амьдрах орчны аюулгүй байдал гээд ийм зүйл байгаад байгаа учраас өөр, өөр статустайгаар, өөр, өөр нутаг дэвсгэрт өрсөлдөж хөгжих, хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах ийм боломжийг эртхэн бүрдүүлье гэж.

Энэ парламентын бас бүрэн эрхийн хугацаанд энэ хот тосгоны хөгжилтэй холбоотой энэ Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой бас нэг том хийх түүхэн өөрчлөлт шинэчлэлт л гэж энийг харж байгаа. Тэгээд та бүхэн маань бас дутуу нь одоо судалж, санал онолоо гаргаад энэ хуулийг дэмжиж, цааш нь хэлэлцүүлэх асуудал дээр анхаарлаа хандуулж өгөөрэй гэж хүсье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд 10 цаг 27 минутаас хуралдааныг даргалав.

Н.Энхболд: Тийм. Тогтохсүрэн даргын микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Яах вэ ЗГ боловсруулаад л хотынхоо ажил хийх гээд байгаа байдлыг нь харахаар бол дэмжмээр байгаа юм. Яг амьдрал дээр энэ яаж хэрэгжих вэ гэхээр тун хүнд байгаа юм. Энэ чинь нэг бүтэц, та нар 3 шатлалтай юмыг 4 шатлалтай болгожхож байна шүү дээ. Алдаржавхлан сайхан хорооны үүрэг нэмж байгаа гээд байна. Хог, нохой, автобусны буудал 3 л байна шүү дээ нэмж байгаа 3 юм чинь, тийм. Уул нь бол та нар анхнаасаа тэр эрх мэдэл нэмье гэж байгаа бол тэр хороон дээрээ л эрх мэдлээ нэмэх ёстой шүү дээ. Хог, нохой, эзэнгүй нохой, эзэнгүй муур, автобусны зогсоол 3 л байна шүү дээ. Өөр юм байхгүй тийм. Тэгэхээр болбол энэ болбол нэг их том амжилтад хүрнэ гэж бол би бол итгэхгүй байна. Тийм. Тэгэхдээ яах вэ тэгээд нэг оролдоод үзэг.

Тэгээд одоо баталсан хууль чинь уул нь бол энийг энэ жил намар 10 сард хэрэгжүүлэх байхгүй юу. 4 жилийн дараа хэрэгжүүлэх хуулиа одоо батлах хэрэг байгаа ч юм уу, үгүй ч юм уу, тийм. Би болбол хэрэв энийг ингээд шуурхай хийх гэж байсан бол та нар 10 сарын сонгуульдаа хамтатгаж хийгээд, нэг циклд оруулж явна уу гэхээс нэг циклгүй хэзээ ч юм урагшаа ахихгүй шүү дээ. Тийм юм хийчхэж байгаа байхгүй юу. Тэгээд яах вэ, иргэд чинь юу гэх нь вэ тэгээд л сонсоод байж байя. Мань хэд ямар нэг их хотын юманд ороод байдаг биш. Иргэд нь юу гэх нь вэ тэгээд л хараад. Иргэдээсээ санал асуусан юм уу энийгээ? Хамгийн гол нь иргэд энийг энийг юу гэсэн юм хотын иргэд. Санал асуугаад маш гоё юм байна тэгье гэсэн юм уу?

Н.Энхболд: Гишүүд түрүүн асуулт тавиад, хариултуудаа авсан. Үг

хэлж дууслаа. Одоо санал хураана. Гишүүдийг сая нөгөө Байнгын хороон дээр зарим гишүүд давхар байж байгаа. Тэнд Сарангэрэл гишүүн байсан. Өөр, Оюунчимэг гишүүн байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хурааа. Тэгэхдээ ажлын хэсэг байгуулж, нэлээд их ярьж, бусад хууль тогтоомжуудтай нийцүүлэх гэх мэтчилэн олон асуудал байгаа шүү гэдгийг бас зориуд хэлье. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт. 11 гишүүнээс 8 нь дэмжиж, 72,7 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Мөнхцэцэг гишүүн танилцуулъя.

10.30 цаг

Хоёр.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Амарсайхан танилцуулна. Ажлын хэсэг түрүүчийн хуулийг хэлэлцэхэд байсан хэвээрээ. Амарсайхан гишүүний микрофоныг өгье.

С.Амарсайхан: Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын хөгжил, хүн амын өсөлт нь хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьшил бий

болох, замын хөдөлгөөнд хэт түгжрэл үүсэх, орчны бохирдол нэмэгдэх зэргээр эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч байгаатай холбоотойгоор бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах, хотын бүх бүтээн байгуулалт, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд шинэ Зуунмод хотыг олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт байгуулах бөгөөд засаг захиргааны хувьд Улаанбаатар хотын дагуул хот статустай байхаар тусгасан. Шинэ Зуунмод хот нь амралт, аялал жуулчлалын, олон нийтийн худалдаа, үйлчилгээний, засаг захиргааны, оюутны хотхон, судалгаа шинжилгээний, тээвэр логистик, олон улсын нисэх онгоцны буудал, агаарын каргоны аж ахуйн нөөц зэрэг 9 бүстэй байхаар зааж, бүсчлэлийн хуваарийг зөвхөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлохоор төлөвлөж байна.

Шинэ Зуунмод хот нь иргэдэд зориулсан ногоон хөгжлийг дэмжсэн, ирээдүйн хотын олон улсын концепцын дагуу нэгдсэн төлөвлөлтийн тогтолцоотойгоор байгуулагдахаар тусгасан. Тодруулбал, оршин суугчийн оршин суугаа газраас 20 минутын газарт сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн тээврийн үйлчилгээний буудал, цэцэрлэгт хүрээлэн, худалдаа үйлчилгээний газар зэрэг байх 20 минут стандарт хот гэсэн концепцын хүрээнд шаардлагыг хангаж төлөвлөнө. Хотын хөгжлийн болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу иргэн, ААНБ-д газар ашиглах эрх олгох асуудлыг зөвхөн төсөл сонгон шалгаруулах зарчмаар шийдвэрлэх ба төсөл болон сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд тавигдах шаардлага,

төсөл шалгаруулах журмыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж батална.

Шинэ Зуунмод хотын удирдлага нь хотын оршин суугчдаас сонгогдсон хотын зөвлөл, захирагч болон Ерөнхий архитектур, хотын хөгжлийн корпорацаас бүрдэх ба зохион байгуулалтын хувьд хороонд хуваарилагдана. Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацыг Төв аймаг болон нийслэл хамтран байгуулж, хотын газар хөгжүүлэлт, бизнес хөгжүүлэлтийг хариуцаж, хөрөнгө оруулагчидтай төсөл, арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ. Шинэ Зуунмод хотын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, бие даан хөгжих баталгаагаар хангах нь төр, нийслэл хот, төв аймгийн үүрэг байх бөгөөд төрөөс бүтээн байгуулалтын явцад татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, улсын төсөвт дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг тусгаж батлах, төрийн байгууллагыг нүүлгэн шилжүүлэх гэх мэт дэмжлэг үзүүлэх зориулалтыг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Мөн хот нь төсөвтэй байх ба тухайн хот дахь татварын орлогын 80 хувийг шинэ Зуунмод хотод, 20 хувийг нийслэл, Төв аймагт хуваарилж зарцуулахаар заасан.

Хууль батлагдсанаар дараах үр дүн гарна гэж тооцож байна. Үүнд, дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх хүрээнд хөрөнгө оруулалт, татварын таатай орчныг бий болгох, шинээр ажлын байр бий болгож, ДНБ болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх, тээвэр логистикийн нэгдсэн төвийг байгуулж, хөгжүүлснээр орон нутгийн болон бүсийн, цаашилаад олон улсын логистикийг сайжруулна. Орон сууцжуулах төсөл хэрэгжүүлж, орон сууцын хангамж нэмэгдэж, нийслэлээс иргэд шилжин суурьших, төрийн байгууллага, их дээд сургууль, коллеж, шинжлэх ухааны байгууллагуудыг нүүлгэх нөхцөлийг мөн бүрдүүлнэ.

Бүс нутгийн тэнцвэртэй байдлын хөгжлийг хангах бодлогын хүрээнд Шинэ Зуунмод дагуул хоттой Төв аймаг нь эдийн засгийн интеграцид нэгдэж, тогтвортой хөгжих нөхцөл бүрдэнэ. Хуулийн төсөл болон дагалдах бусад хууль, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Н.Энхболд: Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуулттай гишүүн байна уу? Ганболд гишүүнээр тасаллаа. Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: 2 зүйл асууя. 1 дүгээрт нь ер нь цаашидаа ингээд нийслэл дагуул хот бүр дээрээ хууль гаргах юм уу? Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль дээр чинь дагуул хот гэсэн тусгай бүлэг байгаа. Энэ харилцаагаараа зохицуулж болоогүй юм уу? Энэ хүрээндээ тодотгол хийгээд ч юм уу, энэ хүрээндээ хуульдаа өөрчлөлт оруулаад явж болоогүй юм уу? Заавал ингэж Шинэ Зуунмод хот гэдэг ийм хууль заавал боловсруулах хэрэг байгаа юм уу? Цаашидаа ингээд улсын зэрэглэлтэй болон дагуул бүх хотууддаа бид нар хууль гаргах юм уу? Эрдэнэт хотын хууль, Дархан хотын хууль, Шинэ Хархорум хотын хууль.

Тэгээд дагуул танайх чинь баахан дагуул хотууд байх юм. Бүх дагуул хот дээр ингэж хууль гаргах уу? Уул нь энийг чинь нэг л хуулиар зохицуулагдчихна Нийслэлийн эрх зүйн байдлын хууль бий шүү дээ. Дагуул хоттой холбоотой асуудлыг бол. Тэгээд дагуул хоттой холбоотой асуудлыг нэг хуулиар яагаад зохицуулчхаж болоогүй юм бэ гэдэг 1 дүгээр асуулт байгаа юм.

2 дугаарт нь газар нутагтай холбоотой асуудал гараад байдаг. Төв аймгийнхан жаахан эсэргүүцэлтэй бол яриад байдаг. Тэгээд энэ хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулаад Төв аймагтай ер нь ойлголцлын асуудлууд ярьсан уу? Одоо энэ хууль гараад ингээд хэрэгжээд явахаар зэрэг ямар нэгэн

асуудал үүсэх үү сөрөг үр дагаврууд гэсэн ийм 2 зүйлийг тодруулъя.

Н.Энхболд: Хэн хариулах вэ? Сайнзориг 4 номер.

П.Сайнзориг: Тогтохсүрэн даргын асуултад хариулъя. Энэ хууль маань бас Хот, тосгоны эрх зүйн байдлын хуультайгаа бол уялдана. Дагуул хот нь бол орон нутгийн зэрэглэлтэй хот байх юм. Орон нутгийн зэрэглэлтэй хотыг дагуул хот байдлаар бас хөгжүүлж болно гээд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль дээр бид нар бас тодорхой заасан байгаа. Өөрөөр хэлэх юм бол 7-гийн, үгүй ээ 4.7 дээр бас байгаа.

Шинэ Зуунмод хотын хувьд бол яагаад бие даасан хуулиар зохицуулах гээд байгаа вэ гэхээр нэлээн онцлог байгаа. Нийслэл болон нийслэлийн харьяа бөгөөд Төв аймгийн газар нутгийг дэвсгэр дээр байж байгаа. Өөрөөр хэлэх юм бол Төв аймгийн хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг хамруулан байгуулж байгаа.

2 дугаарт Хөшигийн хөндий дээр бол олон улсын зэрэглэлтэй энэ манай одоо ганц нисэх буудал маань ингээд байж байгаа. Энийг дагуулж бас Аэро сити маягийн хот байгуулахын тулд бас тодорхой хэмжээний горим төлөвлөлтийн хувьд бас нэлээдгүй онцлогууд байгаа. Бид хэд энэ Төв аймгийн энэ Шинэ Зуунмод хотын асуудал дээр бас яг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хувьд яаж Улаанбаатар, Төв аймаг интеграци буюу эдийн засгийн интеграцид орж хөгжиж болох вэ гэдгийг бас энэ бас загвар болоосой гэж хүсэж, энэ дээрээс орж ирэх орлогыг нь Төв аймагтай хуваалцах байдалтай ингээд явж байгаа.

Одоо Зуунмод хотыг, сумыг бид нар бол улсын зэрэглэлтэй хот болгож хөгжүүлнэ гээд явж байгаа. Энэ Шинэ Зуунмод хот нь бас алсдаа бие дааж одоо бас энэ хоттойгоо нэгтгэж бас

хөгжих бололцоотой байна. Энэ бол тодорхой цаг хугацаанд шилжиж орно гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ бас засаг захиргааны шинэчлэлийн хувьд бас онцлог байгаа. Нэлээн гаднын хөрөнгө оруулалтыг татах, санхүүгийн төв байгуулах, аялал жуулчлал, эргээд энэ Улаанбаатар хотод төлөвлөх боломжгүй зарим бизнесийн үйл ажиллагаанууд дэмжиж бүтээн байгуулалтыг хийх, энэ онцлогоос нь шалтгаалаад жишээ нь захирагчийг бол 6 жилээр томилно гэж байгаа. Бусад орон нутгийн зэрэглэлтэй хотуудыг бодвол улс төрийн циклээс илүү гарсан буюу тодорхой ийм урт хугацаагаар тогтвортой байдлыг хангах зэрэг ийм нөхцөл байдалтай байгаа юм.

Тийм учраас илүү их бие даасан хуулиар хөгжих бололцоотой. Бусад дагуул хот буюу асуудлууд дээр бол бие даасан хууль гарахгүй. Шаардлагатай бол гаргаж болно. Энэ бол Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиараа бол орон нутгийн зэрэглэлтэй хотын зохицуулалт нь үйлчлээд явах юм байгаа юм. Нийслэл Улаанбаатар хотын хуулиараа шууд зохицуулалт ч юм уу, одоогийн зохицуулалтаар явахаар захирагчийг нь шууд Улаанбаатараас томилно гэххээж байгаа юм. Тэгэхээр нөгөө нэг иргэд маань зөвлөлөө сонгож чадахгүй, зөвлөлийн гишүүнээ сонгож чадахгүй, захирагчаа сонгож чадахгүй ч гэдэг юм уу маш олон зүйлүүд нь бас иргэдийн одоо бас дэмжлэгийг авахгүй байх магадлалтай учраас энэ хууль, эрх зүйн орчнуудыг өөрчилж тухайлан хууль явъя. Бусад орон нутгийн зэрэглэлтэй хотуудын асуудлыг Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиараа зохицуулъя гэж байгаа.

Ажлын хэсэгт бол бид нар Төв аймгийн төлөөллийг оролцуулсан. Зуунмод хотын Засаг дарга Сарангэрэл болон Төв аймгийн удирдлагуудад бол бас мэдээллийг бас өгөөд явсан. Улаанбаатар хотын бүсчилсэн хөгжлийн форумар бас Төв аймгийн удирдлагуудыг бас урьсан байгаа.

Тодорхой мэдээллүүд бол бас.../минут дуусав/

Н.Энхболд: *Жаргалмаа гишүүн асуулт.*

Б.Жаргалмаа: *Ер нь сая Тогтохсүрэн дарга бас миний асуултыг асуучихлаа л даа. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль орж ирж байна. Энэ хуультайгаа хэрхэн яаж нийцэж байгаа юм бэ? Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиараа бид нар бас тодорхой хэмжээний асуудлуудыг шийдвэрлэсэн бус уу гэдэг зүйлийг.*

Улсын нийслэлийг Улаанбаатар байна гэдгийг Үндсэн хуулиараа бид нар заагаад өгчихсөн. Гэхдээ бид нар шинэ Хархорум хотыг босгож, улсын нийслэлээ нүүлгэх энэ асуудлыг бас ярьж байгаа. Бүтээн байгуулалтын ажлууд эхэлчихсэн ерөнхийдөө явж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ асуудлуудтай ер нь хэрхэн яаж зохицох вэ л гэдэг зүйлийг би асуух гээд байгаа юм. Нийслэлийн төвлөрлийг сааруулахын тулд дагуул хотуудыг байгуулах, хотын статусыг бий болгох гэдэг дээр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиа бол дэмжиж байгаа. Зуунмод хотыг хот болгоод нийслэлийн нийслэл Улаанбаатар хотдоо байрлаж байгаа байгаа төрийн байгууллагууд Зуунмод руу шилжинэ гэж ойлгох уу, эсвэл Зуунмод хот өөрөө бие даасан эдийн засгийн чөлөөт бүс байх тэр боломжийг нь энэ хуулиараа бид олгож өгөх гэж байгаа юу гэдэг зүйлийг асууя.

Нөгөөтээгүүр сая ярилаа. Аймаг орон нутгийн бүсчлэл, хилийн бүсийн асуудлыг энэ хууль зохицуулж чадах уу, үгүй юү? Өнөөдрийг хүртэл Налайх дүүрэг болон Төв аймгийн Эрдэнэ сум билүү тийм ээ, Эрдэнэ сумын 10963 га газрын асуудлыг нийслэл болон Улаанбаатар хот, Монгол Улсын Засгийн газрын зүгээс шийдвэрлэж чадаагүй, хилийн бүсийн маргаантай асуудал байсаар байгаа. Энэ асуудал шийдвэрлэгдэж чадах уу, үгүй юү?

Амарсайхан даргыг хотын дарга байхад Иргэдийн хурлын даргад Давагийн тавьж байсан бас санал байдаг. Өөрөөр хэлэх юм болбол Богд уулыг тойрсон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах. Хөшөөтийн болон Хөшигийн хөндий болон Майдар хотуудыг хот болгон эдийн засгийн чөлөөт бүсийг бий болгож, тийм ээ эдийн засгийн боломжийг нээх, чөлөөт зах зээлийн зарчмыг тэнд бий болгох гэдэг юм уу ийм асуудал яригдаж байсан. Энэ бүхэн энэ хууль батлагдсанаараа хэрвээ биеллээ олно гэж байвал энэ хуулийг бас нэн түрүүн дэмжмээр байна. Тэгэхээр энэ тал дээр нэг тайлбар өгөөч гэдэг зүйлийг асууя.

Хархорум хот болон Улаанбаатар хотын ангиллын ялгаа, нийслэл Монгол Улсын нийслэл нь Улаанбаатар уу, шинэ Хархорум байх уу, үгүй юу гэдэг дээр. Ер нь ямар төлөвлөлттэйгөөр Шинэ зуун мод хотыг бас оруулж ирж байгаа юм бэ? Тэгээд газар нутгийн бүсийн асуудал дээр. Тогтохсүрэн даргын асуултад түрүүн хариулт авчихсан учраас.

Н.Энхболд: *Сайнзориг 4.*

П.Сайнзориг: *Хархорум хотын асуудал маань эдэлбэр газрыг бол улсын тусгай хэрэгцээнд авчихсан яваа юм байна лээ. Өвөрхангай аймгийн Хархорин сумын тодорхой нутаг дэвсгэр болон Архангай аймгийн Өгий нуур болон Хашаат сумын нутаг дэвсгэрийг хамааруулан авчихсан байж байгаа. Ер нь алсдаа бол 500 мянган хүний суурьшилтай ийм хот байна лээ. Ерөнхийлөгчийн өргөө бас байришина гэсэн ерөнхий төлөвлөлттэй байгаа гэдэг талаар би мэдээллийг солилцсон Ерөнхийлөгчийн Тамгын газрын зөвлөхүүдтэй.*

Ер нь бол яах вэ зүгээр одоогийн Үндсэн хуулиар бол одоо Улаанбаатар хот бол улсын нийслэл байна гээд хуультай. Энэ хүрээндээ л байгаа. Тодорхой хүрээнд бас улсын нийслэлийг өөр хотод байршуулах эсэх асуудал бол

цэвэр Үндсэн хуулийн энэ хүрээндээ Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Энэ бол эргээд бас тодорхой түвшиндээ яригдаж болох байх. Магадгүй одоо юу гэдэг юм зүгээр бусад улс орнууд шиг хос нийслэлтэй байхыг бас үгүйсгэхгүй. 3 нийслэлтэй улс бол байдаг юм байна лээ. Хос нийслэлтэй улсууд бол нэлээдгүй олон байгаа гэх зэрэг энэ боломжууд бол байгаа байх. Тэгэхдээ өнөөдрийн Үндсэн хуулийнхаа хариултаар бол Улаанбаатар улсын нийслэл хэвээрээ байна. Одоо ийм зүйл байна.

2 дугаарт бол Монгол Улсын Улсын Их Хурал болон ЗГ-ын холбогдох шийдвэр гараад, энэ Улаанбаатар хотын төвлөрлийг задлах үүднээс энэ төрийн байгууллагууд буюу яамнуудын кампус хэлбэрээр бас Төв аймаг руу гаргах, Номтын ам руу гаргах энэ асуудал байж байгаа. Үндсэндээ энэ дээр бол холбогдох зураг төслийн ажлууд бол хийгдээд явж байгаа. Ер нь бол тодорхой хэмжээнд энэ ажлууд бол эрчимтэй явна гэсэн үндэслэлтэй байж байгаа. Тэгэхээр би бол бас таны асуултад ингэж хариулахаар байна.

Шинэ Зуунмод хотын хувьд бол үндсэндээ одоо бас газрын гүний чөлөөт бүстэй, тээвэр логистикийн төвтэй, аялал жуулчлалын бүстэй. ШУТИС одоо жишээ нь өчигдөр бид нар бас хамтарсан эрдэм шинжилгээний хурал хийгээд явж байхад бид бас энэ Шинэ Зуунмод хот руу шилжих асуудлаа ингээд хөөцөлдөж эхэлье. 4-өөс 5 жилийн бүтээн байгуулалт явах байх. Энийг Засгийн газар, Улсын Их Хурал дээр дэмжээд өгвөл ШУТИС бас яг тэр төв Шинэ Зуунмод хот руу гармаар байна. Эргээд илүү их инженер, шинжлэх ухаан, инновац шингэсэн тэр боловсон хүчнүүдийг бэлтгэх, энийгээ бас судалгаа шинжилгээ хийж энэ Шинэ Зуунмодуудын концепттой нийцүүлж бас хөгжих, үйл ажиллагаагаа явуулах бүрэн бололцоо бид нарт байна гэдгээ бол илэрхийлж байх жишээтэй байна.

Хилийн цэсийн асуудал бол засаг захиргаа нэгжийн хоорондох асуудал байгаа юм гишүүнээ. Энэ хот байгуулах асуудал маань бол хилийн заагийн асуудал байдаг. Эдэлбэр газар тогтоож өгөх асуудал байгаа. Арай 2 өөр асуудал байгаа. Төв аймгийн Эрдэнэ сум болон Налайхтай холбоотой энэ асуудлуудыг бол одоо бас яах вэ уг нь Газрын тухай хуулийн шинэчлэл хийгдсэн тохиолдолд бас шийдэгдэхээр байсан. Тодорхой түвшинд энэ асуудлыг шийдэх зайлшгүй шаардлага байгаа. Иргэд нь аль хаанаа харьяалалтайгаа мэдэхгүй байна. Үл хөдлөх хөрөнгийн татварыг хаанаа төлөхөө мэдэхгүй байна. Магадгүй маш олон ийм асуудлууд байгаа. Сонгуульд аль талдаа орж санал, сонгуульд оролцох гэдэг юм уу ийм зүйлүүд байгаа учраас энэ Газрын багц хуулийг л.../минут дуусав/

Н.Энхболд: Ганболд гишүүн.

Г.Ганболд: Би яах вэ нэрээс нь эхлээд асууя л даа. Энэ Зуунмод гэж яг ямар утга агуулгатай нэр юм бэ? Ер нь бол дэлхийн улс орнууд чинь нэг шинэ хот байгуулахдаа энэ улс орныхоо түүх, өв соёлыг агуулсан бас өвөрмөц нэртэй тийм нэр өгч гадна, дотнын хүмүүсийн дотнынхны анхаарлыг татах ийм агуулгаар яваад байх шиг байгаа юм. Тэгээд заавал одоо ингээд Шинэ зуун мод гэж нэрлэсэн нь ямар агуулгатай юм 1 дүгээрт нэг асуугаадахъя, өөр нэршил өгч болохгүй юу энэ?

2-т нь ер нь энэ одоо 2 л, 2, 3 хэдэн ч хот барих гээд байна даа. Ерөнхийлөгч нь Хархоринд очих юм шиг байна. Засгийн газар тэгээд Номтын ам гэсэн үү чи сая? Зураг, төсөв нь хийгдэж байгаа шахуу юм ярив уу, үгүй юү? ЗГ тэнд. Парламентын ордон энд үү. Тэгээд 3 газар байх л юм шиг байна тийм үү янз нь? Тэгэхээр чинь энийг жаахан уялдаа холбоогоо ер нь хэдүүлээ хаана хаанаа нэг ярихгүй бол бас хамаагүй ингээд юм яриад баймааргүй байна. Үгүй ээ, энэ чинь одоо 3 тийшээ хоорондоо давхисаар

байгаад энэ чинь баларсан юм болно биз дээ.

Тэгээд нөгөө талаасаа, нөгөө талаасаа энэ шинэ хотууд барихаас одоо ингээд дараа нь аягүй бол шинэ Хархорум хотын энэ эрх зүйн байдлын хууль орж ирэх байх л даа. Тэгээд энийг нэг жоохон байна шүү дээ хэдүүлээ нэг ойлгомжтой болгохгүй бол Хархоринд ингээд 3, 4 сумын зааг дээр 189 мянган га газар авчихжээ тусгай хэрэгцээнд. Тэнд маш олон хүмүүсийн эрх ашиг хөндөгдөж байна. Тэнд оршин сууж байсан, амьдарч байсан хүмүүсийн өвөлжсөө хаваржаа, газар тариалангийн газар, элсний карьер ингээд л янз бүрийн элс, хайрганы карьер, нөгөө Өгий нуурыг тойрсон аялал жуулчлалын нэг хүмүүсийн ингээд гэрчилгээ юмнууд нь гарахаа болихоос эхлүүлээд маш их тээг болж байна.

Тэрэнтэй адилхан яг энэ Эрдэнэ сумын 2, Төв аймгийн 2 сумаас ингээд баахан газар одоо авах нь гэж ойлгож байна шүү дээ тийм ээ тусгай хэрэгцээнд. Авчихсан байгаа тийм ээ. Тэрийг одоо нэг жаахан дэглэмийг нь яг хот байгуулах энэ нэг бид нар чинь ингээд нэг хамгаалж байна гээд хэт томоор аваад, тэгэх тусмаа олон улам олон хүмүүсийн эрх ашиг хөндөгдөөд яваад байгаа юм. Тэгэхээр яг хотынхоо нэг нарийвчилсан юмнуудыг дэглэмүүдийг нь нэг жаахан өөрчлөөд, тэгээд яг тэр сумын тэр газарт орсон хүмүүст нь яг энэ хуулиар яг давуу эрх олгох боломжууд байна уу, үгүй юү? Давуу эрх олгох, нөхөн төлбөр олгох боломжууд байна уу гэдгийг ингэж сайн судалж явахгүй бол одоо хэдүүлээ ингээд бас олон хот яриад л, тэгээд тал тал тийшээ тарамдаад, энэнээсээ болоод ингээд аль, аль хот нь явахаа болих ийм нөхцөл байдал үүсэх вий л гэж зүгээр би санаа зовоод байгаа юм л даа.

Тэгээд энэ дээр тэр нутгийн иргэдэд нь шинээр газар олгох, үгүй ээ шинээр давуу эрх олгох энэ тэр асуудлууд нь энэ хууль дээр орж ирэхгүй юү? Тэр хүмүүст газар нутаг багатай өвөлжсөө,

хаваржааны газрыг нөхөж олгох гэх юм болбол тэрийг хааш нь шилжүүлэх вэ, өөр газар олдохгүй болбол энийг яаж зохицуулахаар төлөвлөж байгаа вэ? Ийм л зүйлүүд асууя.

Н.Энхболд: Нямбаатар дарга 3 номер.

Х.Нямбаатар: Би Ганболд гишүүний асуултад хариулъя. Энэ 2020 онд Улсын Их Хурлаас тогтоол гаргаад, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулах үүрэг даалгаврыг Улсын Их Хурлаас Засгийн газарт өгсөн. Энэ дагуу Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулж, оруулж ирж байгаа гэж ойлгож болно. Яг оноосон тэр нэршилтийн хувьд би хэлж мэдэхгүй. Энэ бүүр одоогоос маш олон жилийн өмнө л Зуунмод хот гэдэг ийм нэртэй байсан. Энийг Энхболд дарга сайн мэдэх байх. Би бол сайн хэлж мэдэхгүй байна. Бид нар бол Их Хурлын тогтоолоор оруулж ирж байгаа.

2 дугаарт Ганболд дарга яг одоо төрийн өндөрлөгүүд Хархорин руу Ерөнхийлөгч нүүгээд, ЗГ-ын ордон энэ Номтын ам, Шинэ Зуунмод хотын орчимд суурьших тухай асуудал бүүр ингээд эцэслэсэн зүйлгүй. Зүгээр Улаанбаатар хотын төв энэ 40 мянгат, бага тойруу дотор байгаа яам агентлагуудын төвлөрлийг сааруулж, шинэ Зуунмод хотыг түшиглэсэн дэд бүтэц дагуу Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр суурьшуулах ийм төвлөрлийг сааруулах энэ хүрээнд ийм төлөвлөлт хийж байгаа гэж та товчхондоо ойлгож болно.

Яг одоогоор тийм ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн орд өргөө Хархоринд нүүгээд, Монгол Улсын ЗГ-ын хуралдааны танхим Номтын аманд байрлах тухай ойлголтоосоо илүүтэй Улаанбаатар хотын яг энэ ерөөсөө 50 га дотор бүх яам, агентлагууд байгаа. Энэ яам, агентлагуудынхаа төвлөрлийг

сааруулъя л гэдэг л ийм агуулгатай. Төрийн захиргааны төв байгууллагуудыг ийшээ шинэ суурьшлынхаа бүс рүү гаргая гэдэг ийм төлөвлөлтийг ЗГ-ын хуралдаан дээр ярилцаад энэний дагуу зураг төсвийн ажлууд хийгдээд явж байгаа. Газар олголттой холбоотой энэ Шинэ зуун модтой холбоотой юм бол ерөөсөө 31 мянган га газрыг нэлээн эрт энэ Хөшигийн хөндий байгуулагдсаны дараа шинэ онгоцны буудал баригдсаны дараа энэ 31 мянган га газрыг Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутгаас тусад нь салгаад улсын тусгай хэрэгцээнд авчихсан.

Одоо энэ хуулийн төслийн 9 дүгээр зүйлд Шинэ Зуунмод хотын газрын менежментийн асуудлыг маш тодорхой дурдсан. Энэ Шинэ Зуунмод хот нь аялал жуулчлал, тээвэр логистик, соёлын бүтээлч үйлдвэрлэл, шинжлэх ухаан технологи, инновац, олон улсын хурал зөвлөгөөний чиглэлээр ийм үндсэн тэргүүлэх чиглэлээр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь батлагдчихсан. Одоо энэ хууль батлагдаад захирагч нь томилогдоод, зөвлөл нь байгуулагдаад, ерөнхий архитектор нь томилогдоод, бидний бодож санаж байгаачлан бас төр хувийн хэвшлийн түншлэлээр орон нутагт тодорхой эрхүүдээ авчих юм бол яг энэ хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу нээлттэй тендер зарлаад, төр хувийн хэвшлийн түншлэлээр энэ чиглэлийн бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэх бэлтгэл ажлуудыг.../минут дуусав/

Н.Энхболд: Тэр юу 4, 3 номерын хугацааг нь нэмээд өгчхөөрэй. Сая ингээж асуулаа шүү дээ Нямбаатар даргаа. Одоо тэр орон нутгийн иргэдэд ямар давуу эрх байх вэ, яаж нөхөн төлбөр тэд нарын тодорхой хэмжээгээр зөрчигдөж байгаа эрх ашгийг яаж өөр зүйлүүдээр нөхөж хангаж өгөх вэ гэдэг асуудал. Би үргэлжлүүлээд яг асуучихъя. Жишээ нь Сэргэлэн, Алтанбулагийн хүмүүстэй ямар ойлголцолтой яваа вэ? Яг энэ асуудлаар. 3 номер.

Х.Нямбаатар: Би энэ юу Батбаяр дарга хариулсан нь зөв байх. Зүгээр яах вэ энэ дээр Энхболд дарга, Ганболд гишүүн хоёрын юунд асуултад хариулахад энэ хуулийн үндсэн үзэл баримтлал бол мэдээж хэрэг тэнд байгаа Сэргэлэн, Алтанбулаг сумын иргэдийн газрын давхцалтай асуудлыг бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу иргэдийг нөхөн олговортойгоор газрынх нь асуудлыг шийдэх, өөр газар дүйцүүлж олгох энэ асуудлууд шийдэгдэнэ. Бид нарын энэ одоо хуулийн үндсэн концепц бол энэ Шинэ Зуунмод хотыг яг төгс төгөлдөр төлөвлөлтийн дагуу хот болгоё. Тийм учраас хэн нэг иргэн, ААН-д давуу байдал олголгүйгээр энэ хуулийн 9 дүгээр, энэ хуулийн төслийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Шинэ Зуунмод хотын газрын менежментийн дагуу газар олголтыг хийе л гэдэг л ийм, зөвхөн төсөл сонгон шалгаруулалтаар энэ хотыг босгож бүтээн байгуулъя. Үүнтэй холбоотой татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг олгоё. Шинэ эдийн засаг хотын эдийн засгийг бий болгоё.

Анх удаагаа корпорацийн зарчимтай хот байгуулъя. Нийт олсон орлогынхоо 20 хувийг Төв аймагт төвлөрүүлж өгье, 80 хувийг нь хот өөрийнхөө хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад зориулъя Нөгөө талдаа Улаанбаатараас ирэх 150 мянган хүний суурьшил, ачааллыг өөр дээрээ шингээж авъя гэсэн ийм л үндсэн агуулга, төлөвлөлттэй байгаа. Хотын энэ газрын тэр 31 мянган га-д давхцалтай байгаа асуудлын талаар Батбаяр дарга хэлэх байх.

Н.Энхболд: 1 номерын микрофон. Асчихлаа.

М.Батбаяр: Энхболд гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ Шинэ зуунмод хотыг байгуулах газрыг улсын тусгай хэрэгцээнд одоо 2012 онд, хамгийн сүүлд бол 2021 онд ЗГ-ын 307 дугаар тогтоолоор авсан. Нийтдээ бол 2 сумын 31 мянган га газар улсын тусгай

хэрэгцээнд авагдсан байгаа. Энэ улсын тусгай хэрэгцээнд 2021 онд хамгийн сүүлд авахад бол нийтдээ энэ 2 сумын 3054 нэгж талбар бол давхцалтай байгаа. Энэ давхцалыг улсын тусгай хэрэгцээнд авахад арилгах, түүнийг нөхөн олговор олгох, шилжүүлэх, буцаан авах гээд энэ журмыг бол ЗГ-ын 287 дугаар тогтоолоор бол бас шийдвэрлэж зохицуулсан байдаг.

Энэний дагуу ажлын хэсэг БХБЯ, Төв аймгийн ЗДТГ хамтарсан ажлын хэсэг, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын ажлын хэсэг ажилласан. Өнөөдрийн байдлаар энэ журмын дагуу нийтдээ 30, энэ нийт газрын эдэлбэр газрын 30 хувийг нь чөлөөлсөн байдалтай ингээд байж байгаа. 34 хувийг нь чөлөөлсөн байгаа өнөөдрийн байдлаар. Түрүүчийн ЗГ-ын хуралдаанд танилцуулсан. Тэгэхээр энэ бол цаашид яах вэ гэхээр нэгэнт зохицуулсан журамтай учраас энэ газрыг шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд буцаан авах, буцаан авсан тохиолдолд нөхөн олговрыг нь олгох гээд тусгай журмаар зохицуулсан байгаа.

Ер нь Шинэ Зуунмод хот энэ Төв аймгийн нутаг дэвсгэр 2 сумын нутаг дамнан оршиж байгаагаараа энэ Шинэ Зуунмод хотыг байгуулах болоод энэ хуулийн үндсэн гол концепт бол ерөөсөө л орон нутгийн хөгжлийг дэмжих, энэ орон нутгийн хөгжлийн интеграцид орох ийм зарчимтай. Тийм учраас бол энэ бүс нутагт шинээр 80 мянган ажлын байр бий болно. Одоо ч энэ бүтээн байгуулалтын явцад нэр бүхий энэ сумаас ажлын байр хангагдах бололцоо өнөөдөр ч нээгдсээр байгаа. Цаашид бол энэ хотын хөгжлийн төлөвлөлтийн дагуу бол.../минут дуусав/

Н.Энхболд: Хэн бэ, 7 номер нэрээ хэлээд Ганболд гишүүний асуултад гүйцээгээд хариулчихъя. 7 номер.

Ц.Баярбат: Ганболд гишүүний асуултад хариулъя. Таны хэлдгээр Шинэ Хархорум хотыг байгуулахтай

холбоотой 189 мянган га газар.../үг тасрав/

Н.Энхболд: Нэр, албан тушаалаа микрофонд хэлчхээрэй. Протоколд ордог юм.

Ц.Баярбат: Барилга хот, байгуулалтын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярбат. Ганболд гишүүний асуултад хариулъя. 189 мянган га газрыг бол улсын тусгай хэрэгцээнд Шинэ Хархорум хотыг байгуулах зориулалтаар авчихсан байж байгаа. Энэ дээр сая ЗГ-ын тухай хуульд өөрчлөлт ороод Газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал нь Ерөнхий сайдын эрхлэх асуудалд шилжчихсэн. Тэгэхээр яг газар зохион байгуулалт, геодези, зураг зүйтэй холбоотой газар чөлөөлөлт, энэ асуудлууд нь бол Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар эрхлээд явж байгаа.

Энэ дээр Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас орон нутагт иргэдийн дунд бол уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад, энэ дээр ямар газруудыг шилжүүлэх, ямар газрууд дээр нь нөхөн олговортойгоор буцаан авах вэ гэдэг тооцоолол судалгаагаар ажлын хэсэг нь гаргачихсан байгаа. Тэгээд энэ асуудлаар хэрвээ нөхөн олговор төлбөрийн асуудлуудыг ЗГ дээр сая танилцуулсан байна лээ. Танилцуулаад ингээд ямар байдлаар эх үүсвэрийг нь шийдвэрлэх вэ гэдгээсээ нэлээн шалтгаалж дараагийн үе шатын арга хэмжээнүүд нь явах юм байна.

Н.Энхболд: Би ганцхан товчхон асуулт Нямбаатар даргаа. Би ганцхан товчхон асуудал. Энэ түрүүн Шинэ Зуунмод хотын тухай асуудал гарч байхад тэр үед тогтоол гарч байхад яригдаж байсан нэг зүйл болбол заавал Улаанбаатар хотын дагуул болох ямар шаардлага байгаа юм бэ? Нэг мөсөн улсын зэрэглэлтэй хот болгоод ингээд явчихвал болохгүй юм уу гэдэг баахан юм ярьж байгаад тэгээд тэр үед ийм

тогтоол гарсан юм байгаа юм. Тэгэхээр яагаад заавал тэгж дагуул хот л байхгүй болбол хөгжиж болохгүй гэсэн ямар үндэслэл байна вэ? Одоохон хураана. 3 дугаар микрофон.

Тэр Зуунмод нэрийн хувьд бол ийм байна лээ. Яг ийм учраас Зуун мод гэдэг нэр зүгээр түүх нь гэж нарийн сайн мэдэхгүй. Зүгээр ахмад хүмүүсийн ярьж байгаагаар болбол Манзуширын амны доод бэлд нэг хэсэг мод бий. Тэр энэ ер нь Монголчууд ийм бөөн модыг дандаа зуун мод гэж нэрлэж байсан тийм уламжлал байдаг юм байна лээ. Тэгээд түүрүн тэр гол Зуунмодны гол дээшээ өгсөөд тэр гол эх авч байгаа хавиас хавьд байдаг нэг бөөн хэсэг модны нэрээр зуун мод гэж нэрлэсэн юм гэнэ лээ гэж яриа би сонсож байсан юм. Тийм, түүхийн. Та товчхон хариулчих, тэгээд санал.

Х.Нямбаатар: Энхболд даргаа ер нь бол юу л даа. Яг ингээд хот өөрөө бие даагаад цаашаа хөгжихөд бол улсын зэрэглэлтэй хот болох бүрэн боломжтой. Бид эхний ээлжид Шинэ Зуунмод хотыг Улаанбаатар хот өөрийнхөө дагуул хот хэлбэрээр хөгжүүлэх тэр үндсэн хөгжлийнх нь гарааны замыг нээж өгөөд, энэний дараа өөрөө бие даагаад татварын орлогоо бүрдүүлээд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнийхөө дагуу ингээд хөгжихөд бол энэ бүрэн боломжтой Энхболд даргаа. Одоо энэ чинь яг ингээд 31 мянган га газар дээр цаасан дээр төлөвлөсөн план зургаас өөр шинэ нисэх онгоцны буудлаас өөр огт тийм бэлэн шийдэлтэй зүйл байхгүй.

Бид эхний ээлжид Алсын хараа 2050 хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг дээр дагуул хот гээд орчихсон. 20 оны ЗГ-ын, Их Хурлын тогтоол дээр дагуул хот гээд орчихсон байгаа учраас л бид нар өргөн барихдаа сая дагуул хот байдлаар оруулж байгаа.

2 дугаарт Энхболд даргаа энэ хамгийн гол бид нар нэг юмыг ойлгох ёстой юм байна лээ. Энэ юу гэвэл

Улаанбаатар хот өөрөө Төв аймагтай хамгийн түрүүнд интеграцид орж байж харилцан бие биеийгээ хөгжүүлнэ. Хөшигийн хөндий рүү Улаанбаатар хот метроны төсөл татаж байж Хөшигийн хөндий, Улаанбаатар хотын хооронд нийтийн тээврийн хамгийн боломжтой тээврийн хэрэгслүүд бүрдэх, түүнийгээ дагасан аялал жуулчлал, бусад энэ Улаанбаатар хотоос тэлэлтийн хувьд гарч байгаа суурьшлаа задалж байгаа энэ бүх барилгажих төслүүдийг Шинэ Зуунмод хот одоохондоо дагуул хотын хэлбэрээр харилцан бие биетэйгээ ойлголцолтой хөгжиж байж илүү хурдан Шинэ Зуунмод хот улсын зэрэглэлтэй, бие даасан хөгжих ийм хотын эрх зүйн үндэс тавигдана гэж бид үзсэн. Ийм 2 юм байгаа гэдгийг хэлье.

Н.Энхболд: Гишүүд асуулт асууж, хариултаа авлаа. Үг хэлэх гишүүд. Сарангэрэл гишүүнээр тасаллаа. Ганболд гишүүн үг хэлье.

Г.Ганболд: Би яах вэ зүгээр нэр дээр бас зүгээр бодно л биз гэж байгаа юм. Бас яах вэ ер нь бол нэг аятайхан нэршилтэй нэр өгч болно л доо. Одоо явцын дунд хэлэлцүүлэг дээр бас санал гаргаж болно биз дээ даргаа. Би бол зүгээр Шинэ зуунмод энэ тэр гээд байхаар бас нэг түүхэн уламжлалтай, нэг бас аятайхан хотын нэр өгөөд явбал гадна, дотнынхны анхаарлыг татах вий л гэж зүгээр хэлсэн юм.

Нөгөө талаасаа Тогтохсүрэн даргаа Байнгын хорооны дараагийн хурлуудаар энэ шинэ Хархорин хотын явцын талаар нэг би мэдээлэл сонсмоор байна. Тэгэхгүй бол тэнд 189 мянган га газар тусгай хэрэгцээнд авчихсан. Тэрэнд нь 3 сумын маш олон иргэдийн өвөлжсөө, хаваржаа, тэгээд л ерөөсөө малчдын эрх ашиг, газар тариалан, нөгөө Хархорин сумын чинь бүх бүтээн байгуулалтын элс хайрга, карьерын аж ахуйнууд бүгд орчихсон. Элс хайрга, карьерын аж ахуй бүгд орчихсон. Одоо тэгээд тэрийг цааши нь ашиглах боломж байдаггүй.

Тэр Өгий нуурыг дагасан нөгөө аялал жуулчлалын бизнес эрхэлдэг нэг гэр бараа ингээд ажиллуулдаг, нэг guest house маягийн ийм ажиллуулдаг хүмүүсийн одоо ингээд гэр бараагаа ажиллуулах зөвшөөрлүүдэд нь ингээд хэзээ тодорхойгүй ингээд зогсчихсон. Тийм учраас энд маш олон хүмүүсийн эрх ашиг, бухимдал байгаа юм. Тэгэхээр энийг нэг ярьж 189 мянган га-гаа хэвээр нь байлгах юм уу, эсвэл 189 мянган га-гаа дотор нь зэрэглэлийг нь буулгаад яг хот байгуулахыг нь тусгай хамгаалалтад, бусдыг нь жаахан орон нутгийн тусгай хамгаалалтад аваад дэглэмийг нь бууруулаад ингээд явахгүй болбол энэ их төвөгтэй байдал үүсэх нь.

Тэгээд нөгөө талаасаа Тогтохсүрэн даргаа ер нь болбол энэ Төрийн байгуулалтын байнгын хороо Их Хурал дээр нэг жаахан энэ төрийн институтүүдийн хоорондын энэ ойлголцол бий болгохгүй болбол одоо нийгэмд Хархоринд Ерөнхийлөгч очих гээд байгаа юм шиг зураг нь хийгдээд одоо явж байна шүү дээ, бодитойгоор ингээд Шинэ Хархорин хотын ажил нь одоо юу билээ нэгжийн нэгж байгуулагдчихсан, том зураг, төсвүүд нь хийгдээд өчнөөн хөрөнгө зараад явж байтал одоо ингээд ЗГ энэ нийслэлийн орлогчийн ярьж байгаагаар чинь энэ Төв аймагт ЗГ-ын ордон байгуулна гээд дахиад зураг төсөв хийгээд байгаа юм шиг юм яриад байх юм.

Тэгээд Төрийн ордон ингээд энэ Улаанбаатар хотод байна гэвэл энэ чинь ямар ч нэгдмэл зохион байгуулалтгүй юм байгаа учраас энийгээ нэг талд нь гаргаж ер нь тогтоол шийдвэр гаргаж, цэгцэлж явахгүй болбол энэ чинь арай болохгүй. Тэгээд энэ дээр нэг ТББХ-ноос нэг сонсож, энэ ЗГ-ын байр суурийг Ерөнхийлөгчийн одоо бүх талынх нь байр суурийг сонсож байж ер нь нэгдсэн нэг ойлголцолд хүрч, тогтоол шийдвэрээр баталгаажуулж явахгүй бол болохгүй юм шиг байна гэсэн санал.

Д.Тогтохсүрэн: Ер нь тэр Ганболд гишүүний хэлснээр дараагийн Байнгын хорооны хурал дээр шинэ Хархорум хотын нөгөө бэлтгэл ажлын явц, тэгээд тэр хот байгуулалтын ажил, тусгай хэрэгцээнд авсан асуудлууд эд нарыг нь нэг яривал яасан юм бэ? Тэгээд ярина гээд тогтчихъё. Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Би энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Дэмжих шалтгаанууд бол байна. 2016 онд анх Хан-Уул дүүргээс Улсын Их Хуралд нэр дэвшиж байхад 104 мянган хүнтэй байсан юм. Одоо Хан-Уул дүүрэг 260 мянган хүнтэй боллоо. Хороо нь 10 гаруй хороотой байсан, одоо 25 хороотой, дахиад хороо нэмэх шаардлагатай байгаа. Ер нь ийм маягаар Улаанбаатар хот тэлээд байдаг, утаатай, түгжрэлтэй, иргэд нь бухимдалтай амьдрах орчин аюултай ийм л байгаа. Тэгээд энийг бид нар хэдэн жил чимээгүй харж суух юм бэ? Хэн нэгэн нь ямар нэгэн юм хийх ёстой.

Би одоогийн нийслэлийн удирдлага бол энэ рүү бол харин зоригтой ханцуй шамлан орж байна гэж бодож байгаа. Энэ хотын төвлөрлийг, энэ утааг бууруулахад бид нар чинь одоо нэг хотоо жаахан задлахгүй, төвлөрлийг сааруулахгүйгээр ер нь яаж энэ байдалтайгаа ингээд яваад байх юм бэ? Улам муудах, улам бид нар мухардалд орох ийм нөхцөл байдал бол бүрэн дүүрэн бүрдсэн нь бид нарын өдөр тутмын амьдралаас харагдаж байгаа. Яах вэ янз бүрийн бас эргээж харах, ажлын хэсэг дээр хэлэлцүүлгийн түвшинд харах зүйлүүд байгаа байх. Тэгэхдээ ямар ч байсан нийслэлийн энэ тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр зориг гаргаад ийм хуулийн төсөл оруулаад ирж байгаа би энэ баг хамт олонд бол талархаж байгаа.

Дээр нь дэмжих шалтгаан гэвэл Нямбаатар даргатай энэ манай

нийслэлийнхэн маань богино хугацаанд үнэхээр одоо бас их ажил хийж байна. Энэ Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгээс Улиастай хүртэлх замыг хэдэн жил ярьсан, хэчнээн сайхан зам одоо ашиглалтад орж байна. Хүмүүс их баярлаж байна шүү дээ. Драгон дээр тэр бүтээн байгуулалтын ажлыг хийж байна. Үгүй ээ, нэг наадам дөхүүлээд бид нар замынхаа нэг цагаан шугамыг татах гэж юу болдог билээ дээ. Хэдэн өдөр болоод зам харгуй хаагаад, иргэдийг бухимдуулаад, түгжрэлийг нэмэгдүүлдэг. Тэгээд маш богино хугацаанд яаж ажил хийж болдог юм бэ? Дарга хүн заавал дөрвөн хананы дунд суухгүй, иргэдийнхээ дунд тулгамдсан асуудал дээр нь очоод, газар дээр нь ажиллаад асуудлыг шуурхай шийдэж болдог юм гэдгийг харуулаад байна л даа.

Тийм болохоор би энэ хуулийн төслүүдээ дэмжүүлчих юм бол энэ нийслэлийн одоогийн тулгамдаад байгаа асуудлыг энэ сонгуультай ямар ч холбоо байхгүй. Ерөөсөө зүгээр Засаг даргын хувьд иргэдийнхээ төлөө хийж байгаа маш том өөрчлөлтийн ийм үүд хаалгыг нээх гэсэн ийм хуулийн төсөл гэж үзэж байгаа учраас энэ 2 хуулийн төслийг бол бид бол дэмжих ёстой. Ярих хөөрөх юм бол байгаа байх. Ингэж л саналаа хэлэх гэсэн юм.

Н.Энхболд: Би нэг товчхон санал хэлчихье. Энэ 2 хуулийг яах вэ, үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжиж болж байна. Тэгэхдээ ийм юм анхаармаар байна Нямбаатар даргаа, гишүүдээ. Ганболд гишүүний ярианд ч түрүүн гарсан. Тэнд байгаа оршин суугчдын эрх ашгийн асуудлыг бид нар заавал бодолцож үзэх ёстой. Энэ дээр та нарын үндэслэл дээр энэ нөгөө нэг юу байна шүү дээ зохицуулалтын үр нөлөөг тандан судалсан байдал гэдэг дээр үндсэндээ хэний ч эрх зөрчигдөөгүй, яагаагүй хөндөгдөөгүй гэсэн ийм л тайлбарууд баахан биччихэж. Яг хэрэг дээрээ тэнд байгаа хүмүүсийн эрх ашиг том, жижиг ямар нэгэн байдлаар хөндөгдөнө. Үүнийг бид нар цаашдаа

хэлэлцэх явцдаа заавал авч хэлэлцэх хэрэгтэй.

Хуульдаа биш юм гэхэд одоо би жишээ нь санал болгох гээд байна. Тогтоол дотор тэнд байгаа хүмүүсийн асуудлыг эрх ашгийг нийцсэн ямар үйл ажиллагаа явуулах хэрэгтэй вэ гэдгийг ядаж дагаж гарч байгаа тогтоолд наад зах нь суулгах хэрэгтэй. Би зүгээр ийм санал хүртэл 2, 3 газар хэлж байсан. Жишээ нь Төв аймгийн Сэргэлэн сум, Алтанбулаг сумын тэр газар нь газрыг нь авснаас болоод эрх ашиг нь тодорхой хэмжээгээр хөндөгдөж байгаа улсууд эсхүл тэр 2 сумын иргэд хэрэв өөрснөө хүсвэл шууд тэр сумын биш хотын иргэний харьяалалтай байдаг, тэр хэмжээгээрээ нөгөө бүтээн байгуулалтын ажил, хот, хотын үзүүлж чаддаг үйлчилгээнд илүү хамрагддаг. Гэхдээ тэр хавьдаа амьдраад байх нөхцөл бололцоотой ийм зүйлийг хүртэл бодолцох хэрэгтэй.

Тэгэхгүйгээр энэ болбол бас нэлээд их тийм асуудал болоод байдаг юм шүү гэдгийг би хэлье. Энийг тэгэхээр би тогтоол дээр ажлын хэсэг гарах байх. Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг гаргасан нь дээр. Тал талын Байнгын хороодоос хүмүүс оруулж байгаад тэр ажлын хэсэгт бас зориуд санал болгож өгнө. Хотынхон энийг ярилцахдаа тэрийг бас анхаараарай гэж хэлэх байна. Гишүүд санал хэлж дууслаа.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай анхдагч хууль, түүний хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн асуудлаар томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 7, 11 гишүүн санал хураалтад оролцож, 7 нь дэмжиж 63,6 хувиар энэ санал дэмжигдэж байна. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Сарангэрэл гишүүн.

11.09 цаг

Хэлэлцэх асуудал дууслаа. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дуусаж байна. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Нямбаатар даргаа саяын тэр ярьсан юмнуудыг та нар тэр сайн анхаараарай. Тийм. Хэлэлцэх асуудлын жагсаалтад өнөөдөр орчихсон байгаа шүү дээ эд нар чинь, тийм.

Тэгэхээр өнөөдөр орчих байх. Тийм.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*

